

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ТАЙЛАН

2022



badrakh
energy

МЭНДЧИЛГЭЭ

Марк Мелеард,

“Бадрах Энержи” ХХК-ийн Гүйцэтгэх захирал



“Бадрах Энержи” ХХК Монгол Улсын хувьд анхны газар доор уусган олборлох үйлдвэрлэлийн туршилтыг байгаль орчин, хүн, малын эрүүл мэндэд сөрөг нөлөөгүй гүйцэтгэлээ.

Манай компани 2020 оны Тогтвортой хөгжлийн тайлангаа гаргаснаас хойш томоохон ажлуудыг, тухайлбал, Дорноговь аймгийн Улаанбадрах сумын нутагт орших Зөвч-Овоо ордод үйлдвэрлэлийн туршилтаа амжилттай хэрэгжүүлээд байна.

Үйлдвэрлэлийн туршилтаа 2021 оны 7 дугаар сард эхлүүлж 2022 оны 12 дугаар сард нэг ч ажлын зогсолттой осол гаргалгүй мөн байгаль орчинд ямар нэг нөлөөлөлгүй гүйцэтгэлээ. Тус туршилтын хүрээнд ГДУО аргаар 10 тонн уран гарган авч, хээрийн ангид зохих стандартын дагуу хадгалж байна. Монгол Улсын Цөмийн энергийн комиссоос 2023 оны 8 дугаар сард Цөмийн энергийн тухай хуулийн 15.1.3 дугаар заалтын дагуу “Бадрах Энержи” компанид цацраг идэвхт ашигт малтмал эзэмших, ашиглах, борлуулах зөвшөөрөл олгосныг дурдахад таатай байна.

Манай хамт олон 2023 оны 6 дугаар сард ажлын зогсолттой осол гаргалгүй 3 жил ажилласан ололт амжилтаа тэмдэглэснийг хуваалцахад таатай байна. Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтыг 2021-2022 онд хэрэгжүүлэх хугацаанд ТЭЗҮ-д нэмэлт тодотгол оруулахад шаардлагатай тоон мэдээлэл цуглуулснаас гадна ГДУО аргаар олборлох нь байгаль орчинд маш бага

нөлөөтэй төдийгүй тус ордыг ГДУО аргаар олборлох нь төслийг үр ашигтай явуулах зөв арга технологи гэдгийг батлаад байна. Үүнийг Монгол Улсын Шинжлэх ухааны академид үйлдвэрлэлийн туршилтын өмнө болон дараа нь хийсэн хөндлөнгийн хяналт үнэлгээ, Мал эмнэлгүүдийн дундын хоршооноос хийсэн малын эрүүл мэндийн томоохон хэмжээний судалгаагаар тогтоосон билээ.

Манай компани Зөвч-Овоо төслийн ТЭЗҮ-г 2023 онд нэмэлт тодотгол оруулан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд өргөн бариад байна.

Манай хамт олон үйлдвэрлэлийн туршилтын хугацаанд Дорноговь аймгийн Улаанбадрах сум, Сайншанд сумын Зүүнбаян багтай байгуулсан Хамтын ажиллагааны гэрээний хүрээнд сум, орон нутгийн оролцогч талуудтай хэлэлцэж зөвлөлдсөний үндсэн дээр малын эрүүл мэнд, байгаль орчин хамгаалал, ус хангамж, боловсролыг дэмжих төслүүдэд 2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийлээ. Эдгээр төслүүд сум, орон нутгийн иргэдийн сайн сайхан хийгээд эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж, өгөөжөө өгсөөр байна.

Зөвч-Овоо төсөл бол Монгол Улсын ураны салбар дахь хамгийн ахисан шатанд яваа төсөл юм. Манай компани тус төслийг хэрэгжүүлснээр Монгол Улсад уул уурхайн шинэ салбарыг хөгжүүлж байна. Иймд олон нийтэд ураны олборлолтын талаар боловсрол, мэдээ мэдээлэл тогтмол өгч, зөв ойлгуулах шаардлагатай. Компанийн хувьцаа эзэмшигчдийн санал нэгдсэн өргөн хүрээний мэдээлэл, харилцааны төлөвлөгөөг 2021-2022 онд хэрэгжүүлэхдээ үйлдвэрлэлийн туршилт, уг төсөлд ашиглаж байгаа технологийн талаар тайлбарлах, сум, орон нутгийн иргэдийн асуултад хариулах зэрэг ажлуудад чиглүүлсэн билээ. Мөн Монгол улсын уламжлалт болон нийгмийн сүлжээн дэх хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтын ажиллагаагаа өргөжүүлж, манай компанийн үйл ажиллагаа болон ураны салбарын талаарх хуурамч мэдээ мэдээлэлтэй тэмцэхэд анхаарлаа.

Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтыг амжилттай хэрэгжүүлсэн нь төслийн олборлолтыг эхлүүлэхэд бас нэг чухал алхам болсон юм. Төслийн хувьцаа эзэмшигчид болох “Мон-Атом” ХХК, “Орано Майнинг”, Монгол Улсын Засгийн газар нь Хөрөнгө оруулалтын гэрээний яриа хэлэлцээг хийж эхэлсэн ба 2023 оны сүүлээр гэрээ байгуулахаар ажиллаж байна.

Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулснаар 2028 онд эхлэх Зөвч-Овоо төслийн үндсэн олборлолтын бэлтгэл ажлууд эхлэх юм. Ингэснээр жилд 2,500 тонн уран олборлож, 800 гаруй үндсэн ажлын байр, гэрээт компаниудаар дамжуулж мөн 800 ажлын байр тус тус бий болно. Зөвч-Овоо ордын үндсэн олборлолтын 33 жилийн хугацаанд улсын төсөвт 2 тэрбум ам.долларыг татвар, хураамж байдлаар төвлөрүүлж, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд бодитой дэмжлэг болох нийгмийн төслүүдэд жилд 1 сая ам.доллар зарцуулна.

Энэ нь 2006 оноос эхлэн нийгмийн хөгжлийн төслүүдэд манай компаниас зарцуулсан 8 тэрбум төгрөгийн туслалцаа дэмжлэгийн үргэлжлэл байх болно.

Монгол Улсын эдийн засгийн сэргэлт болон экспортыг солонгоруулахын зэрэгцээ дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах хүчин чармайлт, нүүрстөрөгч бага ялгаруулан эрчим хүч үйлдвэрлэхэд шаардлагатай нөөцөөр дэлхий дахиныг хангахад хувь нэмрээ оруулж хамтран ажиллах болсондоо манай хамт олон баяртай байна.

ОНЦЛОХ ТОО, БАРИМТ



УРАНЫ ТОГТООГДСОН НИЙТ НӨӨЦ

87,667 тонн уран
(Зөөвч-Овоо, Дулаан-Уул /
Өмнөтийн ордууд)



2006 ОНООС ХОЙШ СУМ,
ОРОН НУТАГТ НИЙТ

7,8 тэрбум төгрөг
хөрөнгө оруулсан



ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТӨЛБӨРТ
ЖИЛД

1,05 тэрбум төгрөг



НИЙТ ХАНГАН НИЙЛҮҮЛЭЛТИЙН

97 хувийг
Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн
нэгжүүдээс хийдэг



НИЙТ 104 АЖИЛТАНТАЙГААС

96 хувь нь
Монгол ажилтнууд



МОД ТАРИАЛАЛТ

7500 заг
мод тариалав



ЦАЦРАГ ХАМГААЛАЛ

Олон улс болон Монгол улсын
стандартаар мэргэжлийн шарлагын
жилийн дээд хязгаар

20 мЗв/жилд

“Бадрах Энержи” ХХК-ийн
цацрагтай ажиллагчийн 2022 оны
дундаж тун

0.9 мЗв/ж

Уушигны рентгэн зураг авахуулах
үеийн тун

0.1 мЗв/ж



ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР
2010-2022 ОНД НИЙТ

184 оюутанд тэтгэлэг олгосон



МАЛЖУУЛАХ ТӨСӨЛ

2007 оноос хойш нийт **112**

малчин өрх хамрагдсанаас

84 нь Улаанбадрах сумаас

38 нь Сайншанд сумын
Зүүнбаян багаас хамрагдав

АГУУЛГА

ЦӨМИЙН ЭРЧИМ ХҮЧ НЬ НҮҮРСТӨРӨГЧ
БАГА ЯЛГАРУУЛДАГ ЦАХИЛГААНЫ ЭХ
ҮҮСВЭР 7

МОНГОЛ-ФРАНЦЫН ХАМТАРСАН
“БАДРАХ ЭНЕРЖИ” ХХК 9

БИДНИЙ ГҮЙЦЭТГЭЛ 11

1 БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ.....	12
2 ШИЙДВЭР ГАРГАЛТ	16
3 ХҮНИЙ ЭРХ.....	18
4 ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ.....	22
5 ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЦАЦРАГ ХАМГААЛАЛ.....	26
6 БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮЗҮҮЛЭЛТ	30
7 БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ.....	38
8 ХАРИУЦЛАГАТАЙ ҮЙЛДВЭРЛЭЛ.....	41
9 НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА.....	43
10 ОРОЛЦОГЧ ТАЛУУД.....	46

“Бадрах Энержи” ХХК

2023 оны 11 дүгээр сар

Зураг чимэглэл: © “Бадрах Энержи” ХХК - © Орано / Фредерик Ожэ - © Shutterstock / Anton Balazh, Denis Burdin, Linegold
Тайлангийн дизайн: BCerise



УРАН БОЛ УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТТЭЙ ТЭМЦЭХЭД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ НӨӨЦ ЮМ

Цөмийн эрчим хүч нь нүүрстөрөгч бага ялгаруулдаг цахилгааны эх үүсвэр

Дэлхийн хүн амын тоо өсөн нэмэгдэж, хэрэглэгчид цахилгаан тээврийн хэрэгсэл рүү шилжихийн зэрэгцээ хөгжиж буй улсуудын эдийн засаг улам бүр тэлж байгаа тул 2050 онд дэлхий нийтэд өнөөдрийнхөөс хоёр дахин их цахилгаан эрчим хүч шаардлагатай болно. Үүний сацуу залруулж болшгүй уур амьсгалын өөрчлөлтөөс урьдчилан сэргийлэхийн тулд хүн төрөлхтөн CO2 буюу нүүрстөрөгчийн ялгаруулалтыг 50 хувиар бууруулах шаардлагатай. Хүлэмжийн хийн ялгарлыг огцом бууруулахын тулд CO2 буюу нүүрстөрөгчийн үндсэн эх үүсвэр болсон шатдаг ашигт малтмал (нүүрс, байгалийн хий) хэрэглэдэг цахилгаан эрчим хүчний салбар нүүрстөрөгч бага ялгаруулах шаардлагатай.

Монгол улс уур амьсгалын өөрчлөлтөд илүүтэй өртөж байна

Дэлхийн агаарын дундаж хэм өнгөрсөн 100 жилд 0.86 °C-ээр нэмэгдсэн бол Монголд өнгөрсөн 80 жилд агаарын дундаж хэм 2.25 °C-ээр өсжээ. Ойн түймэр, үер зэрэг уур амьсгалын болон байгалийн гамшигт үзэгдлүүд өнгөрсөн 20 жилд хоёр дахин нэмэгдэв. Газар зүйн байршил, уур амьсгалын онцлог хүчин зүйлсээс шалтгаалан Монгол улс нь уур амьсгалын өөрчлөлтөд хамгийн өртөмхий улсуудын нэг болоод байна.



Монгол Улс: дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг арга хэмжээнүүдэд хувь нэмрээ оруулах боломж

Монгол Улс нь 200 000 тонн ураны батлагдсан нөөцөөрөө дэлхийд 12-т жагсаж байна. Тиймээс, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэхэд дэлхий нийтэд шаардлагатай стратегийн ач холбогдол бүхий баялгаа нийлүүлснээр нүүрстөрөгч бага ялгаруулдаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхэд чухал үүрэгтэй байж чадна.

Цөмийн эрчим хүч болон уран үйлдвэрлэлийн хувьд ирээдүйтэй хэтийн төлөв

Дэлхий дээрх цөмийн эрчим хүчний станцын тоо өссөөр байна.

- Өнөөдөр дэлхий дээр 445 цөмийн реактор ажиллаж байгаа (дэлхийн цахилгаан эрчим хүчний 10 хувийг хангаж байна) бол шинээр 54 цөмийн реактор баригдаж байна.
- 30 орчим улс цөмийн эрчим хүчний хөтөлбөрөө анхаарч үзэн, төлөвлөж эсвэл шинээр эхлүүлээд байна.

- Мөн бага чадлын модуляр реактор (SMR буюу Small Modular reactor) зэрэг шинэ технологи хөгжиж байна.

2040 он гэхэд ураны хэрэгцээний өсөлтийн талаарх таамаглал:

- “Улаан ном – 2020”-д бичсэнээр дэлхийн ураны хэрэгцээ нэг жилд 100 000 тонн хүрэх магадлалтай.
- Хятад улс 2060 он гэхэд нүүрстөрөгчийн ялгаруулалтаа тэглэх хөтөлбөрөө хэрэгжүүлсэн байх зорилт тавин цөмийн эрчим хүчийг хөгжүүлэхэд ихээхэн хөрөнгө оруулж байна. Ирэх арван жилүүдэд Хятад улс ураны зах зээлийн тэргүүлэгч худалдан авагч болох боломжтой. 2021 оны эхний байдлаар дэлхий дээр баригдаж буй 54 реакторын 16 нь Хятад улсад баригдаж байна.

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

2022 оны 2 дугаар сард Европын Комисс цөмийн эрчим хүчийг ногоон эрчим хүчний ангилалд албан ёсоор оруулсан. Үүнийг Европын Холбоонд тулгараад байгаа уур амьсгалын өөрчлөлт, эрчим хүчний хараат бус байдлын асуудлын өнцгөөс авч үзвээс нүүрстөрөгч бага ялгаруулдаг эрчим хүчний үйлдвэрлэл рүү шилжихэд түлхэц өгч байна.



МОНГОЛ - ФРАНЦЫН ХАМТАРСАН “БАДРАХ ЭНЕРЖИ” ХХК

“Бадрах Энержи” ХХК

Монгол-Францын хамтарсан “Бадрах Энержи” ХХК нь Дорноговь аймгийн нутаг дахь дэлхийн хэмжээний Зөвч-Овоо ураны ордыг ашиглах төдийгүй Монгол улсад уран олборлолтын салбарыг хөгжүүлэх зорилготой ажиллаж байна.

Хоёр улсын төрийн өмчит компанийн хамтарсан компани болохын хувьд “Бадрах Энержи” компанийн хэрэгжүүлж байгаа төсөл нь Монгол, Франц улсуудын хамтарсан төсөл юм. “Бадрах Энержи” ХХК олон улсад шалгарсан туршлага бүхий стандартыг мөрдөж, байгаль орчин хамгаалал, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэнд, орон нутгийн иргэдтэй хөгжүүлж ирсэн харилцан яриа, хамтын ажиллагааны хувьд шилдэг үзүүлэлттэй ажиллаж буйдаа бахархаж байна.

“Бадрах Энержи” ХХК-ийн хувьцаа эзэмшигчид

2013 оны 10 дугаар сард байгуулсан Хувьцаа эзэмшигчдийн гэрээ ёсоор “Бадрах Энержи” компанийн:

- 66 хувийг Орано групп,
- 34 хувийг Монголын улсын засгийн газрыг төлөөлөн “Мон-Атом” ХХК эзэмшиж байна.

“Мон-Атом” ХХК нь 2017 онд “Бадрах Энержи” ХХК-ийн 34 хувийг шилжүүлэн авснаар “Бадрах Энержи” ХХК Монгол-Францын хамтарсан компани болов.



“Эрдэнэс Монгол” ХХК

100%

“Мон-Атом” ХХК

34%



Орано / CFMM

100%

* “Орано Майнинг” ХХК

66%*

“Бадрах Энержи” ХХК

* салбар компани “АРЕВА Монгол” ХХК-иар дамжуулан



“Мон-Атом” ХХК нь Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 45 дугаар тогтоолоор “Уран болон бусад төрлийн цацраг идэвхт ашигт малтмалын геологи хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд дангаар болон бусад хуулийн этгээдтэй хамтран оролцох, төрийн төлөөллийг зохих хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлэх” үндсэн чиг үүрэгтэйгээр 100 хувь төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдсан.

Монгол Улсын Засгийн Газрын 2019 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 4 дүгээр тогтоолоор “Мон-Атом” ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлж тус компанийн охин компани хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулж байна.

Тус компани нь өнөөдрийн байдлаар цацраг идэвхт ашигт малтмалын геологи, хайгуул, олборлолтын төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагаанд төрийн төлөөллийг зохих хуулийн дагуу хэрэгжүүлдэг. “Мон-Атом” ХХК нь Францын Орано групп, Чехийн Чех Ураниум Индастри, Хятадын Чайниз Нэйшинл Нуклеар Корпорэйшн мөн Оросын Росатомтой хамтарсан төслүүдийг хэрэгжүүлж байна.

Цөмийн материалын салбарт хүлээн зөвшөөрөгдсөн Орано групп нь одоо ба ирээдүйд дэлхийн эрчим хүч болон эрүүл мэндийн салбарт тулгарх сорилтыг даван туулах шийдлийг боловсруулдаг. Орано групп нь салбарын мэдлэг туршлага, орчин цагийн дэвшилтэт технологийг бүрэн эзэмшсэн чадвартаа суурилж үйлчлүүлэгчдээ цөмийн түлшний бүтээн эргэлтийн бүх үе шатанд өндөр үнэ цэнэ шингэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээгээр хангадаг.

Орано Майнинг - уран олборлолтоор тэргүүлэгч 3 компанийн нэг

Орано Майнинг компани нүүрстөрөгч ялгаруулалгүй цахилгаан эрчим хүч үйлдвэрлэдэг үйлчлүүлэгчиддээ байгалийн ураныг найдвартай нийлүүлэх зорилттой ажиллаж, дэлхийн дулаарлын эсрэг арга хэмжээнүүдэд хувь нэмрээ оруулж байна. Орано групп нь Монгол улсад туршлага, нөү-хаугаа авчирч, Монголын мэргэжилтэн, шинжээчидтэй хамтран ажилладаг.

Орано Майнинг компани нь:

- Дэлхийн олон улс оронд уран олборлосон 70 жилийн туршлагатай
- Казахстан улс дахь дэлхийн хамгийн том ГДУО ураны уурхайн нэг дээр олборлолт явуулж байгаа ба уг технологийн эксперт
- Канад, Нигер, Казахстан улсуудад урт хугацаанд түншлэл хөгжүүлж ирсэн
- Монгол, Узбекистан, Канад улсуудад хөгжүүлэлтийн шатанд яваа төслүүд дээр ажиллаж байна.

2020-2030 он хүртэлх хариуцлагатай амлалт үүргийн замын зураглалын дагуу Орано Майнинг компани дараах үүрэг амлалтыг хүлээж байна: Үүнд:

- Үйл ажиллагаанаасаа үүсэх CO₂ болон түүнтэй адилтгах хийн ялгарлыг бууруулж, ажиллаж буй улс орнууддаа нүүрстөрөгч ялгаруулалгүй эрчим хүч үйлдвэрлэх явдлыг дэмжинэ.
- Үйл ажиллагаа явуулж байгаа улсынхаа иргэдийг ажлын байраар хангах, үндэсний аж ахуйн нэгжүүдээс хийх худалдан авалтыг өндөр түвшинд байлгана.

- Олборлолт болон төсөл хөгжүүлж байгаа буй бүх сайтууд дээрээ ISO 14001 ба 18000 стандартыг нэвтрүүлнэ.
- Их, дээд болон мэргэжил олгох сургуулиудтай хамтарч компанийн ажилтнууд, нутгийн иргэдийг чадавхжуулж, хөгжүүлнэ.
- Уул уурхайн төслийг эхлүүлэх төдийгүй олборлолтын туршид төсөл дэх олон нийт болон төрийн байгууллагын төлөөллийн оролцоог хангаж, тусгайлсан бүтцээр дамжуулан харилцан ярилцаж, зөвлөлдөнө.
- Орон нутгийн иргэдийг сонсохын зэрэгцээ нийгмийн хөтөлбөрийн хувьд эн тэргүүний чиглэлийг тодорхойлж, ус, эрчим хүч, эрүүл мэнд, боловсрол ба орон нутгийн эдийн засгийн хөгжлийг дэмжсэн төслүүдийг илүүтэй хэрэгжүүлнэ.

I Орано Майнинг компанийн суурь үнэт зүйлсийн нэг нь ил тод байдал

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгыг 2003 онд байгуулагдсан цагаас нь дэмжиж, тус байгууллагын жишгийн дагуу ажиллаж байгаа улс орнууд нь зөвшөөрсөн тохиолдолд веб хуудастаа орлого болон байгуулсан гэрээнүүдээ ил тодоор байршуулдаг.

ОНЦЛОХ НЬ

ЗӨӨВЧ-ОВОО ТӨСӨЛ

"Бадрах Энержи" ХХК-ийн хэрэгжүүлж буй Зөвөч-Овоо төсөл нь Монгол улсад ураны олборлолтын чиглэлээр хамгийн ахисан шатанд яваа төсөл юм.

Тус компани нь Дорноговь аймагт Дулаан-Уул/Өмнөт болон Зөвөч-Овоо гэх гурван ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг. Зөвөч-Овоо ордоос ГДУО аргаар уран олборлох, боловсруулах үйлдвэрлэлийн туршилтыг "Бадрах Энержи" ХХК 2021 оны 7 дугаар сараас 2022 оны 12 дугаар сард хийж гүйцэтгээд байна. Үйлдвэрлэлийн туршилтын үр дүнд "Бадрах Энержи" ХХК нь 10 гаруй тонн байгалийн ураныг олборлосон ба Зөвөч-Овоо ураны ордыг ГДУО аргаар байгаль орчин, хүнд аюулгүйгээр олборлох боломжтойг баталгаажуулж чадсан.

Орано компани гуч гаруй жил үргэлжлэх Зөвөч-Овоо төслийн ирээдүйг баталгаажуулах харилцан ашигтай Хөрөнгө оруулалтын гэрээг Монгол улсын Засгийн газартай байгуулах зорилт тавин ажиллаж байна. Зөвөч-Овоо төсөл нь гуч гаруй үргэлжлэх бөгөөд жилд 2500 тн уран олборлох хүчин чадалтай байж, шууд болон шууд бус 1600 гаруй ажлын байр бий болгох юм.



БИДНИЙ ГҮЙЦЭТГЭЛ

1 | БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ 12

2 | ШИЙДВЭР ГАРГАЛТ 16

3 | ХҮНИЙ ЭРХ 18

4 | ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ 22

5 | ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЦАЦРАГ ХАМГААЛАЛ 26

6 | БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮЗҮҮЛЭЛТ 30

7 | БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ 38

8 | ХАРИУЦЛАГАТАЙ ҮЙЛДВЭРЛЭЛ .. 41

9 | НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА 43

10 | ОРОЛЦОГЧ ТАЛУУД 46

1 | БИЗНЕСИЙН ЁС ЗҮЙ



“Бадрах Энержи” ХХК нь нийгмийн хариуцлагатай уул уурхайн компанийн хувьд ёс зүй, үнэнч шударга байдлыг эрхэмлэж, энэхүү хандлагыг дэмжих үйл явц, зан үйлийг бий болгож, дагаж мөрдөхийг эрмэлздэг. Байнгын яриа хэлэлцээ, зөвшилцөл, ил тод байдал нь оролцогч талуудтай итгэлцэл бий болгож, цаашид тогтвортой үйл ажиллагааг бий болгоход чухал ач холбогдолтой гэдэгт бид итгэдэг.

“Бадрах Энержи” ХХК нь Орано группийн охин компанийн хувьд Группийн Авлигаас урьдчилан сэргийлэх дараах 8 тулгуур үйл ажиллагаанаас бүрддэг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг. Үүнд:

Авлигын эсрэг зураглал

Авлигын эрсдэлийн зураглалын зорилго нь компанийн хэмжээнд авлига, зүй бус нөлөөллийн эрсдэлт нөхцөл байдлыг тодорхойлох, үнэлэх, ангилах бөгөөд байгууллага болон үйл ажиллагаа тус бүр, тэдгээрийн удирдлага, үйл ажиллагаа болон дэмжих хэсгийн үйл явцыг хамарна. Эрсдэлийн зураглал гаргаснаар тодорхойлсон авлига, зүй бус нөлөөллийн боломжит эрсдэлүүдийг бууруулахад чиглэсэн урьдчилан сэргийлэх, илрүүлэх үр дүнтэй тогтолцоо бий.

болгож, түүнийг бэхжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулах боломжтой болдог.

Авлигын эрсдэлийн зураглалын арга аргачлалыг доор дэлгэрүүлэв.



Гуравдагч талын нийцлийн үнэлгээ

Гуравдагч талын нийцлийн үнэлгээ нь гуравдагч талуудын үл нийцэл, ялангуяа авлига, зүй бус нөлөөллийн эрсдэлийг үнэлэх аргуудыг тодорхойлох зорилготой. Нийцлийн үнэлгээ нь компани хамтран ажиллахаар төлөвлөж буй эсвэл хамтран ажилладаг үйлчлүүлэгч, зуучлагч, ханган нийлүүлэгч, туслан гүйцэтгэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч, зөвлөх, ивээн тэтгэлэг ба санхүүгийн дэмжлэг хүлээн авагч, хамтарсан компани, боломжит худалдан авагч зэрэг одоогийн ба ирээдүйн бүх гуравдагч талуудыг хамарна.

Нийцлийн үнэлгээг гуравдагч талтай анх хамтран ажиллах үед, хамтын ажиллагаагаа шинэчлэх үед эсвэл тодорхой цаг хугацаанд дараах үе шаттайгаар гүйцэтгэнэ. Үүнд:

1. “СКОР” цахим талбар дахь “Өөрийгөө шалгах” (self-check) нэртэй “Гуравдагч талын үнэлгээний дотоод маягт”-ын дагуу гуравдагч талын авлигын эрсдэлийн түвшнийг урьдчилан үнэлнэ.
2. Болзошгүй эрсдэлийн түвшнийг харгалзан шаардлагатай бол нэмэлт шалгалт хийнэ.
3. Үнэлгээгээр тодорхойлсон эрсдэлийн түвшин болон шийдвэрийг (үргэлжлүүлэх/зогсоох, таатай/таагүй санал, зөвлөмж) баталгаажуулна.

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

Ёс зүй ба ажил хэргийн зан төлөвийн дүрэм “Бадрах Энержи” ХХК нь Орано группийн Ёс зүй ба ажил хэргийн зан төлөвийн дүрмийг дагаж мөрддөг. Тус дүрэм нь авлига, зүй бус нөлөөлөл, түүнчлэн хориотой зан төлөвөөс зайлсхийхэд баримтлах төрөл бүрийн зарчмууд болоод зохистой зан төлөвүүдийг тодорхойлсон бодлогын үндсэн баримт бичиг юм. Байгууллагын хэмжээнд ёс зүйтэй, авлигаас ангид байх арга барилыг хэрэгжүүлэх компанийн дээд удирдлагын үүрэг амлалтыг тус дүрмээр бэхжүүлсэн ба ажилтан нэг бүрээс гадна компанийн ханган нийлүүлэгчид болон бизнесийн түншүүд өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөх үүрэгтэй.



УУЛ УУРХАЙН ЗАРЧИМ

Тогтвортой хөгжлийг дэмжих хүрээнд ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагаа явуулж, компанийн засаглал, ил тод байдлын зөв тогтолцоог хэрэгжүүлэх

Нийцлийн сургалт

Компанийн ажилтнууд Ёс зүй, ажил хэргийн зан төлөвийн дүрмийн сургалтад цахимаар хамрагдах үүрэгтэй. Үүнд шинэ ажилтнууд орох ба хуучин ажилтнууд хоёр жил тутамд сэргээн суух ба сургалтын бүртгэлийг жилийн эцсийн үнэлгээгээр тулган баталгаажуулдаг. Сургалт монгол болон бусад гадаад хэлээр байдаг. Жил бүр компанийн гүйцэтгэх удирдлагаас гадна эрсдэлд өртөх магадлалтай ажилтнуудад “Авлига, зүй бус нөлөөллөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр нийцлийн сургалт зохион байгуулдаг.



“Бадрах Энержи” ХХК нь Орано группийн шүгэл үлээх талбараас гадна Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу өргөдөл, гомдол хүлээн авах саналын хайрцаг ажиллуулдаг. Ялгаварлан гадуурхалт, аливаа ёс зүйн зөрчлийн хохирогч болсон гэж үзвэл ажилтан уг хайрцагаар дамжуулан гомдол, саналаа гаргах боломжтой.

Нягтлан бодох бүртгэлийн хяналт

Нягтлан бодох бүртгэлийн хяналт нь компанийн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн мэдээлэлд тулгуурлан болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх зорилготой юм. Тэр дундаа авлигын эрсдэлийн зураглалаар тодорхойлсон эрсдэлтэй гүйлгээг тусгайлан хянадаг.

Компани гурван түвшний хяналт, шалгалтыг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Түвшин 1: Санхүүгийн аудит
- Түвшин 2: Хараат бус шалгалт
- Түвшин 3: Дотоод аудит



Мониторинг ба үнэлгээ

Нийцлийн хөтөлбөрийн үр дүнг дараах байдлаар үнэлдэг. Үүнд:

- Компанийн гүйцэтгэх захирал болон Орано группийн удирдлагад танилцуулсан үзүүлэлтүүдийн мониторинг;
- Орано группийн Нийцлийн хэлтсээс хэрэгжүүлдэг компанийн нийцлийн хяналт шалгалтын төлөвлөгөө;
- Нийцлийн үйл ажиллагааны хүрээнд хийдэг үр дүнгийн дотоод үнэлгээ;
- Орано группийн Эрсдэл, дотоод аудитын хэлтсийн гүйцэтгэдэг хяналт шалгалт

Сахилгын арга хэмжээ

Манай компани авлигын шинжтэй ямар ч үйлдлийг “үл тэвчих” бодлого баримталдаг. Хууль тогтоомж, Ёс зүй, ажил хэргийн зан төлөвийн дүрэм зөрчсөн, биелүүлээгүй болон ажил үүргээ гүйцэтгэж байхдаа ажилтан зохисгүй үйлдэл гаргасан тохиолдолд зөрчлийн хэмжээг харгалзан дараах сахилгын арга хэмжээ авдаг:

- Анхааруулах / сануулах
- Түдгэлзүүлэх
- Албан тушаал бууруулах
- Ажлаас чөлөөлөх.

2022 онд компанийн хэмжээнд зохион байгуулсан нийцлийн арга хэмжээ

Компанийн ажилтнууд Ёс зүй, ажил хэргийн зан төлөвийн дүрмийн сургалтад цахимаар хамрагдах үүрэгтэй. Үүнд шинэ ажилтнууд орох ба хуучин ажилтнууд хоёр жил тутамд сэргээн суух ба сургалтын бүртгэлийг жилийн эцсийн үнэлгээгээр тулган баталгаажуулдаг. Сургалт монгол болон бусад гадаад хэлээр байдаг. Жил бүр компанийн гүйцэтгэх удирдлагаас гадна эрсдэлд өртөх магадлалтай ажилтнуудад “Авлига, зүй бус нөлөөллөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр нийцлийн сургалт зохион байгуулдаг.

- Компанийн удирдах ажилтнууд эрсдэлийн зураглал гаргаж, үнэлгээ хийв.
- Орано группийн Нийцлийн хэлтэс төлөвшлийн хяналт шалгалт гүйцэтгэв.
- Эрсдэлд өртөх магадлалтай ажилтнуудад авлига, зүй бус нөлөөллөөс урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулж, сургалтын материалыг Монгол хэл рүү хөрвүүлэн, дотоод сүлжээнд нийт ажилтнууд нэвтрэх боломжтой байдлаар байршуулав.



- Холбогдох ажилтнууд өгсөн/хүлээн авсан бэлэг сэлт, урилгаа тайлагнаснаас гадна энэ талаарх сануулгыг тодорхой давтамжаар илгээж, бэлэг сэлт, урилгын бүртгэлийг шинэчилсэн.
- Гуравдагч талын үнэлгээг тухай бүр хийсэн ба тодорхойлсон эрсдэлийн түвшнээс шалтгаалан Орано группийн Нийцлийн хэлтэс дараагийн шатны шалгалтуудыг гүйцэтгэв.
- Ёс зүй, ажил хэргийн зан төлөвийн дүрмийг шинэчилж, нийт ажилтнуудад цахим шуудангаар илгээж, дотоод сүлжээнд байршуулаад байна.
- Ёс зүй, ажил хэргийн зан төлөвийн дүрмийг гуравдагч талуудтай байгуулсан гэрээний салшгүй хэсэг болгон оруулав.
- Ажилтнууддаа ёс зүйн аливаа зөрчлийг шүгэл үлээх талбараар дамжуулан мэдээлэхийг жилийн туршид цахим шуудангаар тодорхой давтамжтай илгээж сануулснаас гадна ажлын байрууд дахь мэдээллийн самбарт шүгэл үлээх зааварчилгаа бүхий зурагт хуудас байршуулсан.



2 | ШИЙДВЭР ГАРГАЛТ



УУЛ УУРХАЙН ЗАРЧИМ

Байгаль орчин, нийгэм, засаглалын зарчмыг компанийн үйл ажиллагааны стратегид шингээх

“Бадрах Энержи” ХХК нь компанийн стратеги, шийдвэр гаргах үйл явцад тогтвортой хөгжлийн зарчмыг тусгаж ажилладаг

Хариуцлагатай уул уурхайн компанийн хувьд “Бадрах Энержи” ХХК нь бүхий л нөөцийн удирдлага, ашиглалтаа тогтвортой, харилцан зөвшилцсөн бөгөөд тэнцвэртэй байдлаар явуулан олборлолтын шат бүр дэх нийгэм, байгаль орчин, техник, эдийн засгийн сорилтыг шийдвэрлэж байна.

Ийнхүү “Бадрах Энержи” компани нь “Цөмийн материалыг хувиргах, удирдан хянах ноу-хау хөгжүүлж, уур амьсгал, эрүүл мэндийг хадгалан хамгаалж, одоо ба ирээдүйд нөөц баялгийг хэмнэлттэй ашиглах дэлхийн төлөө” хэмээх Орано группийн бодлого, зорилгыг хэрэгжүүлдэг.

Компанийн удирдлага

I Төлөөлөн удирдах зөвлөлийн ажиллагаа

“Бадрах Энержи” компанийн Төлөөлөн удирдах зөвлөл нь компанийн үйл ажиллагааны уялдаа холбоо, тасралтгүй байдлыг хангах үүрэгтэй юм. Монгол улсын Компанийн тухай хуулийн дагуу ТУЗ-ийн дарга, Гүйцэтгэх захирлын чиг үүргийг хооронд нь зааглах шаардлагыг компани үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш хэрэгжүүлж байна. “Бадрах Энержи” компанийн дүрмээр ТУЗ-ийн зохион байгуулалт, үйл ажиллагаа ба эрх, үүргийг тодорхойлж өгсөн. ТУЗ жилд хоёроос доошгүй удаа хуралдаж, компанийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэрүүдийг гаргаж байна.

Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл “АРЕВА Монгол” ХХК (Орано Майнинг компанийн салбар), “Мон-Атом” ХХК, Цөмийн энергийн комиссын Ажлын алба, Ашигт малтмал, газрын тосны газрын төлөөлөл бүхий гишүүдтэй ажиллаж байна.



ТУЗ-ийн дэргэд Үйл ажиллагааны хороо, Аудитын хороо ажилладаг. Компанийн хувьцаа эзэмшигчдийн төлөөлөгчид нь Аудитын хороог жил жилээр ээлжлэн даргалдаг. Хороод жилд дөрвөөс доошгүй удаа хуралдаж, компанийн үйл ажиллагаа, санхүүг хэлэлцэж, шаардлагатай тохиолдолд асуудлыг ТУЗ-д танилцуулан хэлэлцүүлж, зохих шийдвэрийг гаргуулдаг.

I Удирдлагын баг

“Бадрах Энержи” компани нь төвлөрсөн бус үйл ажиллагааны загварын дагуу ажилладаг. Өөрөөр хэлбэл, компанийн удирдлага, хяналтын чиг үүргийг компанийн төв оффисоос хэрэгжүүлдэг. Компанийн удирдлагын баг үйл ажиллагааны хэлтсийн захирлуудаас бүрддэг бөгөөд Орано группийн ёс зүйн дүрэм болон тогтвортой хөгжлийн талаар компанийн хүлээсэн үүргийн биелэлтийг хангадаг.

Ханган нийлүүлэлт

“Бадрах Энержи” компани ханган нийлүүлэгчидтэйгээ харилцан хүндлэл, итгэлцэл, бүтээлч харилцаа, хамтын хүчин чармайлтын зарчимд тулгуурлан олон улсын стандартыг хангасан урт хугацааны хамтын ажиллагааг хөгжүүлэхийг эрмэлзэж ажилладаг.

“Бадрах Энержи” ХХК-ийн ХАБ, Байгаль орчин, Хууль, нийцлийн хэлтсүүд нягт хамтран ажиллаж, туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгч нар авлига, ашиг сонирхлын зөрчил үүсгэж болох нөхцөл байдлаас урьдчилан сэргийлдэг.

I Хууль дүрмийн нийцэл, ёс зүй, ил тод байдал

Ханган нийлүүлэлт, худалдан авалтыг Монгол Улсын төдийгүй олон улсын холбогдох хууль тогтоомж, стандарт, дүрэм журмын хүрээнд явуулдаг.

“Бадрах Энержи” ХХК-ийн ханган нийлүүлэгчидтэй байгуулж буй гэрээний үндсэн нөхцөл болзол буюу гэрээний зүйл заалт нь хамтран ажиллах байгууллагын ХАБЭМ-ийг сахих, байгаль орчныг хамгаалах үүрэг амлалтыг илэрхий тусгадаг.

Гэрээгээр хүлээсэн амлалт үүргээ биелүүлээгүй тохиолдолд тухайн гэрээг хүчингүй болгодог.

I Худалдан авах үйл явц

Компанийн журмын дагуу өрсөлдөхүйц үнийн санал авч, улмаар үнийн харьцуулалт хийх нь худалдан авалтын үйл ажиллагааны нэг чухал хэсэг ба нийцлийн үнэлгээ хийсний дараа нийлүүлэгчийг бодит шалгуурын дагуу шударгаар сонгон шалгаруулдаг.

I Чанар ба аюулгүй байдал

Чанар, аюулгүй байдлыг эрхэмлэх нь нийт ажилтнууд, гэрээлэгчдийн хувьд чухал зорилт юм. Энэ ч утгаараа ажлын зогсолттой осол, хүний амь эрсэдсэн осолгүй өдрийн тоо зэрэгт гэрээлэгч, нийлүүлэгчдийн үзүүлэлтийг оруулан тооцдог. Гэрээлэгчид мөн компанийн “ХАБ-ын сар” арга хэмжээ, ХАБ-ын сургалтад хамрагдаж, ХАБ-ын зорилтын нэг хэсэг болдог.

I Байгаль орчинд ээлтэй байх

Байгаль орчин хамгаалах, болзошгүй нөлөөллийг бууруулахад хог хаягдлыг ангилан ялгаж, хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж байна. Үүний зэрэгцээ, байгаль орчинд шууд нөлөөлж болохуйц бүх төрлийн ажилд оролцох нийлүүлэгчдийн гэрээнд тогтвортой хөгжлийн амлалтыг тохиролцон тусгадаг.

3 | ХҮНИЙ ЭРХ



УУЛ УУРХАЙН ЗАРЧИМ

Компанийн ажилтнууд болон компанийн үйл ажиллагаанд өртсөн орон нутгийн иргэдийн хүний эрх, ашиг сонирхол, соёл, зан заншил, үнэт зүйлсийг хүндлэх

“Бадрах Энержи” ХХК нь хүний эрхийг хамгаалсан үндсэн зарчмуудыг баримтлан үйл ажиллагаагаа явуулдаг. Ийнхүү, компани хүүхдийн хөдөлмөр, тулгасан эсвэл хүчээр хөдөлмөр эрхлүүлэх бүхий л хэлбэрийг халах, ажилтнуудын эвлэлдэн нэгдэх, хувийн нууц хадгалах бөгөөд хамтын гэрээ байгуулах эрхийг хангах амлалт үүргээ биелүүлж байна.

“Бадрах Энержи” ХХК нь Орано группийн хүний нөөцийн бодлогыг хэрэгжүүлдэг. Компанийн хүний нөөцийн баг чиг үүргээ хэрэгжүүлэхдээ олон талт байдлыг хөхүүлэн дэмждэг. Гарал үүсэл, нас, хүйс, арьс өнгө, бэлгийн чиг хандлага эсвэл айдентити буюу бусдаас ялгарах байдал, хөгжлийн бэрхшээл, улс төр, үйлдвэрчний эвлэл, шашны байгууллагын гишүүнчлэл эсвэл үндэсний цөөнх зэргээс шалтгаалсан аливаа гадуурхлаас зайлсхийн, ажилтнуудын ур чадвар, ажлын замналыг хөгжүүлдэг.

Тэргүүлэгч ажил олгогчийн хувьд “Бадрах Энержи” компани төслөө амжилттай хэрэгжүүлэх зорилгоор авьяас, ур чадвартай ажилтнуудыг ажилд авч, хөгжүүлэн, удаан хугацаанд ажиллуулахыг эрмэлзэж байна.

Манай ажилтнууд

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар “Бадрах Энержи” компани нийт 91 ажилтантайгаас байнгын ажлын байранд 74 хүн ажиллаж байгаа бол 4 нь гадаад мэргэжилтэн байна. Харин 13 ажилтан хугацаат гэрээгээр ажиллаж байна. “Бадрах Энержи” ХХК-ийн үндсэн үйлдвэрлэлийн бүтээн байгуулалт эхлэх үед олон тооны мэргэжлийн боловсон хүчин шаардлагатай болох ба Зөвөөч-Овоо үйлдвэрлэлийн туршилт дээр ажиллаж байсан ажилчдаа юун түрүүнд эргүүлэн авах юм.

“Бадрах Энержи” ХХК ажилтнуудаа, тухайлбал өрсөлдөхүйц цалин бүхий ажлын байрны замналыг санал болгож, ажил, амьдралын тэнцвэр мөн чанартай хөдөлмөрийн харилцааг дэмждэг.



2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх ажилтнуудын мэдээлэл

Ангилал	Хүйс		Нийт
	эмэгтэй	эрэгтэй	
Байнгын гэрээт ажилтан	19	55	74
Хугацаат гэрээт ажилтан	1	12	13
Гадаад ажилтан	0	4	4
Нийт	20	71	91



I Орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нь

“Бадрах Энержи” ХХК үйл ажиллагаа явуулж байгаа бүс нутгийнхаа хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого баримталж ирсэн. Үйлдвэрлэлийн туршилтын хугацаанд нийт ажилтнуудын 96 хувь нь Монгол улсын иргэд байсан бөгөөд тэдний 33 хувь нь Дорноговь аймгийн Улаанбадрах сум болон Сайншанд сумын Зүүнбаян багийн иргэд байв. “Бадрах Энержи” компани уурхайн талбай дахь нарийн мэргэжил үл шаардах ажлын байруудад ажилтан авахдаа хүний нөөц бүрдүүлэх журмынхаа дагуу Дорноговь аймгийн иргэдэд тэргүүн ээлжид давуу эрх олгодог.

2021–2022 онд орон нутгаас 15 ажилтан шинээр ажилд авсан. Тодруулбал:

Бүс нутаг	Ажилд авсан хүний тоо
Сайншанд	2
Зүүнбаян	3
Улаанбадрах	8
Замын-Үүд	2
Нийт	15

I Мэдлэгийн менежмент, ажилтнуудын сургалт, хөгжил

Жил тутам компани хоёр хэсгээс бүрдэх ажлын гүйцэтгэлийн үнэлгээний кампанит ажлыг зохион байгуулдаг. Үүнд:

- **Гүйцэтгэлийн үнэлгээ:** үүгээр ажилтны өмнөх жилийн ажлын гүйцэтгэлийг үнэлж, ирэх жилийн зорилгыг тодорхойлдог.
- **Мэргэжил хөгжлийн ярилцлага:** үүгээр ажилтны ур чадвар, мэргэжлийн хүсэл зорилгыг хөгжүүлэхэд чиглэдэг. Ажил мэргэжлийнхээ талаарх хүсэл эрмэлзэл, хөгжүүлэхийг хүсэж буй ур чадварынхаа талаар менежертэйгээ ярилцаж, давуу тал болон сайжруулах чиглэлийнхээ талаар санал зөвлөгөө авч, хөгжлийн төлөвлөгөө гаргах боломж олгодог.

I Сургалт

Жил бүр компанийн ажилтнууд шаардлагатай ур чадвар, мэдлэгтэй болох мөн мэргэжлийн хувьд өсөж хөгжих зорилгоор Монгол улс болон гадаад улс дахь сургалтын төвүүд дэх сургалтад хамрагддаг.

“Бадрах Энержи” компани 2021–2022 онд дараах сургалтыг ажилтнуудынхаа дунд амжилттай зохион байгуулсан. Үүнд:

- Магадлан итгэмжлэгдсэн их сургуулиудын зэрэг горилх хөтөлбөр
- Зөөлөн болон техникийн ур чадвар олгох сургалтын хөтөлбөр
- Ур чадварын гэрчилгээ олгох сургалт
- Англи, франц хэлний сургалт



ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

Гүйцэтгэлийн үнэлгээнээс гадна хоёр жил тутам Ажилтны үнэлгээ гэсэн кампанит ажлыг зохион байгуулдаг. Удирдлага болон хэлтсүүдийг хамруулан Хүний нөөцийн хэлтсээс зохион байгуулдаг уг кампанит ажил нь ажилтнуудын өсөлт хөгжил, хөгжлийн төлөвлөгөөний талаар авч үздэг.



Сургалтад хамрагдсан ажилтнууд, хувиар

Сургалтын төрөл	2021 онд	2022 онд
Магадлан итгэмжлэгдсэн их сургуулиудын зэрэг горилх хөтөлбөр	8	7
Зөөлөн болон техникийн ур чадвар олгох сургалтын хөтөлбөр	47	14
Хэлний сургалт	31	18
Заавал хамрагдах сургалтууд	Нийт ажилтан	Нийт ажилтан

Үүнээс гадна компанийн 7 ажилтан 2022 онд Франц улсад зохион байгуулагдсан олон улсын болон группийн сургалт, семинарт оролцсон.

I Цалингийн бодлого

Компани жил бүр цалингийн үнэлгээ хийж цалин урамшууллын бодлогоороо дараах чиглэлийг хангах зорилготой. Үүнд:

- Гүйцэтгэл, чадварыг үнэлэх (компани доторх үндсэн ур чадвар, экспертиз)
- Цалингийн түвшнийг тэнцүүлэх
- Төсвийн нийцлийг хангах
- Өрсөлдөхүйц байдлыг хангах.

I Олон талт байдал

Олон талт байдал нь гүйцэтгэлийн хүчин зүйл, инновацийн эх үүсвэр болохын зэрэгцээ мэдлэг, мэдээллийн солилцоог бэхжүүлэн, ур чадвар сорьж, эргэцүүллийг хөгжүүлдэг гэдэгт Орано групп итгэдэг.

I Бүтээлч нийгмийн харилцаа

“Бадрах Энержи” ХХК-ийн хүний нөөцийн бодлого нь одоогийн хууль тогтоомжийн хүрээнд талуудын хооронд яриа хэлэлцээ хийх, зөвлөлдөх зарчмыг үндэс болгодог. Компанийн эрүүл зохистой ажиллах чухал нөхцөл нь хариуцлагатай, бүтээлч нийгмийн харилцаа юм.

2022 оны 11 дүгээр сард “Бадрах Энержи” ХХК хоёр жил тутам бүх ажилтны саналаар сонгогддог ажилтнуудын төлөөлөлтэй хийсэн Хамтын гэрээгээ шинэчлэн батлав.



ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу Хамтын гэрээг дүүргийн засаг даргын тамгын газарт бүртгүүлдэг. Гэрээний хэрэгжилтийг ажилтнуудын төлөөлөлтэй хамтран хянадаг. Ажилтнуудын сонгосон таван төлөөлөл удирдлагын багтай яриа хэлэлцээ хийж, тэдний эрх ашгийг компанийн бодлого, шийдвэрт тусуулдаг.

Хамтын гэрээг 2022 оны 11 дүгээр сард хоёр жилийн хугацаатай шинэчилсэн. Компанийн удирдлага ажилтны төлөөлөлтэй улирал бүр уулзаж, Хамтын гэрээний хүрээнд дотоод журмын шинэчлэл, цалингийн нэмэгдлийн журам, хээрийн нэмэгдэл, хоолны мөнгийг нэмэгдүүлэх боломж, унааны мөнгө болон ажилтнуудын сургалт, хөгжлийн төлөвлөгөө зэрэг чиглэлээр ярилцаж, санал солилцдог.

Хөдөлмөрийн нөхцөлийн чанар

Дорноговь аймгийн нутаг дахь Зөөвч–Овоо хээрийн ангид хоёр долоо хоногийн ээлжтэй 30 гаруй ажилтан байрлан ажиллаж байна. Хээрийн анги дээр фитнес, сагсан болон хөл бөмбөг, билльярд мөн ширээний теннисээр хичээлэх боломжтой. Ингэснээр ажилтнууд хээрийн ангид чөлөөт цагаа тав тухтай өнгөрүүлж чаддаг. 2022 оны 1 дүгээр сарын 1–ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулиар компанийн ажилтнууд хоёр долоо хоногийн ээлжийн хуваарийг мөрдөж эхэлсэн.

Улаанбаатар хотын оффисын ажилтнуудад спортоор хичээллэхэд нь зориулж 2022 оноос эхлэн жил бүр 600,000 хүртэлх төгрөгийг компаниас олгодог.

Компанийн Улаанбаатар, Сайншанд хотын оффисын ажилтнууд Улаанбаатар, болон Сайншанд суман дахь оффисын ажилтнууд 8:00–9:30 цагийн хооронд ажилдаа ирж, 17:00–18:30 цагийн хооронд тарах уян хатан нөхцөлтэй ба ингэснээр өглөө, орой хүүхдүүдээ сургууль, цэцэрлэгт нь хүргэх, авах зэргээ оргил ачааллын үеэр зохицуулах боломж олгодог.

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

Ажил амьдралын тэнцвэр “Бадрах Энержи” компани Ковид–19 цар тахлын хөл хорио цуцлагдах хүртэл бүх ажилтнаа гэрээс нь буюу зайнаас ажиллах боломж бүрдүүлсэн. 2022 оны 10 дугаар сарын 1–нээс долоо хоногт нэг өдөр зайнаас ажиллах горимд шилжсэн.



I Ажилтны тэтгэмж урамшуулал

Урамшуулал

Компанийн захирал болон ажилтнууд тухайн жилийн зорилт, ажлын гүйцэтгэл, ажилласан хугацаа зэргээс хамаарсан урамшуулал авахаас гадна ажилласан жилийн урамшууллыг 3–аас дээш жил компанид ажилласан ажилтнуудад жил бүр олгодог.

Нэмэгдэл

Компани ажилтнууддаа Улаанбаатар, Сайншанд хотын оффист ажилласан өдрүүдэд нь өдрийн хоолны нэмэгдэл, Дорноговь аймаг дахь хээрийн ангид ажилласан өдрүүдэд нь хээрийн нэмэгдэл тус тус олгодог ба Улаанбаатар хотоос хээрийн анги руу зорчих тохиолдолд замын хүнсний мөнгө болон унааны зардлыг тус тус олгодог.

Цалинтай чөлөө, нэг удаагийн тэтгэмж

Компани ажилтнуудынхаа аз жаргалтай, баяр, гунигтай үеүүдэд дэмжлэг болох үүднээс дараах тохиолдлуудад цалинтай чөлөө, нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгодог. Ажилтан гэрлэлтээ батлуулах, бүл нэмэх, ажилтны хүүхэд хуримаа хийх, ажилтны гэр бүлд гачигдал тохиох зэрэгт 3–5 хоногийн цалинтай чөлөө, нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгодог.

Нийгмийн хамгаалал

Хамтын гэрээний дагуу компанийн ажилтнууд нэмэлт эрүүл мэндийн даатгалд бүрэн хамрагддаг ба ойрын гэр бүлийн гишүүд болон 21 нас хүрээгүй хүүхэд нь 85 хүртэлх хувь хэмжээнд хамрагддаг.

Өндөр насны тэтгэвэрт гарах, орон тооны цомхотголд орох, тухайн албан тушаалд ур чадвараар тэнцэхгүй зэрэг шалтгаанаар ажилтны хөдөлмөрийн гэрээг дуусгавар болгох тохиолдолд компанид ажилласан жилээс нь хамааруулж 12 хүртэлх сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгодог.

Мөн компаниас тэтгэвэрт гарсан ахмад ажилтнуудаа жил бүр эрүүл мэндийн үзлэгт хамруулж, Цагаан сар, Ахмадын баяраар мөнгөн тэтгэлэг олгож байна.

Өрх толгойлсон ганц бие эцэг, эхэд жилд нэг удаа мөнгөн тэтгэлэг олгохоос гадна ажилтны гэр бүлд эрүүл мэндийн шалтгаантай хүнд үе тохиолдсон үед нэг удаагийн санхүүгийн дэмжлэг үзүүлдэг.



4 | ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТ



УУЛ УУРХАЙН ЗАРЧИМ

Шинжлэх ухааны үндэслэлтэй, оролцогч талуудынхаа эрсдэлийг хэрхэн хүлээн авч буйг харгалзан үзсэн эрсдэлийн удирдлагын оновчтой, үр дүнтэй стратеги, тогтолцоог бүрдүүлэх



Эрсдэлийн менежмент

“Бадрах Энержи” ХХК нь Орано группийн нэг хэсэг болохын хувьд жил бүр бизнесийн эрсдэлийн загварын дагуу бүх төрлийн эрсдэлийг илрүүлэх, үнэлэх ажлыг хийж гүйцэтгэдэг. Үүний дагуу эрсдэлийн менежментийн үйл ажиллагааны төлөвлөгөөндөө нэмэлт тодотгол оруулж ажилладаг.

BRM буюу бизнесийн эрсдэлийн загварт 40 эрсдэлийн бүлгийг тодорхойлсон ба ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчин, компанийн үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, стратеги мөн группийн санхүүжилт, даган мөрдөж буй одоогийн дүрэм журам, түүнчлэн группийн нийгэм, байгаль орчны талаарх амлалт үүрэгт нөлөө үзүүлж болохуйц урьдчилан таамаглах боломжтой эсвэл гэнэтийн нөхцөл байдал, үйл явдлуудыг хамруулан авч үзсэн.

“Бадрах Энержи” ХХК нь өөрийн компани болон үйл ажиллагаагаараа холбоотой бусад байгууллагууд, гэрээний харилцааны дагуу ажиллаж буй туслан гүйцэтгэгч, ханган нийлүүлэгчдэд Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөх шаардлага тавьж, тэдний үйл ажиллагаатай холбоотойгоор хүний эрх, эрүүл мэнд, байгаль орчны зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлэхэд онцгой анхаардаг.

Эрсдэлийг тодорхойлох, үнэлэх кампанит ажил нь дараах үндсэн зорилготой. Үүнд:

- Бүх төрлийн эрсдэлийг албан ёсоор тодорхойлох,

- Эрсдэлийг эрэмбэлэх зорилгоор шинж чанарыг нь тодорхойлох,
- Эрсдэлийг хянах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх.

Жил бүр боловсруулан гаргадаг эрсдэлийн зураглал бүхий “duty of care plan” –ийг ТУЗ–ийн хурлаар баталдаг.

Эрсдэлийн менежментийн хяналт

“Бадрах Энержи” компани эрсдэлд суурилсан хяналтыг хэрэгжүүлж ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалж, байгаль орчинд учирч болзошгүй нөлөөлөөс ажилтнууд, орон нутгийн иргэд, түүнчлэн соёлын өвийг хамгаалж, ажлын байрны аюулгүй байдлыг хангаж ажилладаг. Төслийн барилга, байгууламжийн зураг төсөл, барилга угсралт, ашиглалт, нөхөн сэргээлт, ашиглалтаас гаргах бүх үе шатанд цацрагийн аюулгүй байдлыг мөрддөг. “Бадрах Энержи” компани Монгол улсын бүх хууль, тогтоомжоос



гадна Орано группийн цөмийн аюулгүй байдлын дүрмийг мөрдлөг болгон ажилладаг.

Эдгээр тогтолцоо нь талбай дээр тулгарч буй томоохон аюулыг удирдах, эрэмбэлэх, хянах, засаж залруулах, өөрчлөх арга хэмжээ авах, цаашлаад журам тогтоох боломж бүрдүүлдэг.

Үйлдвэрлэлийн эрсдэл

Компанийн аюулгүй ажиллагаа хариуцсан баг үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлж, аливаа тохиолдлыг тогтмол хянаж бүртгэн, дүн шинжилгээ хийж, улмаар бүх ажилтнуудад мэдээлдэг.

Осол, өндөр эрсдэл бүхий нөхцөл байдал үүсэх бүрт холбогдох баг, хэлтсүүдэд албан ёсоор мэдээлж, эргэх холбоотой ажиллаж байна. Ингэснээр баг, хэлтсүүдэд урьдчилан сэргийлэх арга хэмжээ авахад бэлэн байх, үйлдвэрлэлийн аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо, хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн ач холбогдлыг сануулж хамтран ажилладаг.



бэлтгэлтэй байж, сар бүр шаардлагатай сургалт, дадлагыг зохион байгуулдаг.

“Бадрах Энержи” ХХК нь эмнэлгийн яаралтай тусламжийн багтай бөгөөд үндсэн болон гэрээт ажилтнуудад анхны тусламж болон эрүүл мэндийн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлдэг.

Аюулгүй ажиллагааны дасгал сургуулалт

Монгол Улсад уул уурхайн шинэ салбарыг хөгжүүлэн ажиллаж байгаагийн хувьд эрсдэлт нөхцөлд хариу арга хэмжээ авах, техникийн болон үйл ажиллагааны тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, олон харилцагч, оролцогч талуудын хүрээнд шаардлагатай менежмент хийх нь компанийн хувьд хариуцлагатай аж ахуйн нэгж болоход нөлөөлөх чухал үүргүүдийн нэг юм. “Бадрах Энержи” компани нь орон нутгийн онцгой байдлын хэлтэс нэгжүүдтэй аюулгүй ажиллагаа, байгалийн гамшиг, цацрагийн осол зэрэг сэдвээр сургуулалт төлөвлөн зохион байгуулж, хамтран ажиллаж байна.


Дасгал сургуулалтын үеэр компанийн ажилтнууд болон бусад оролцогч талуудад бэлэн байгаа шуурхай ажиллагааны системийг ажиллуулах боломж олгохоос гадна нийт ажилтнууд онцгой байдлын үед авах арга хэмжээ болон хэрхэн хамтран ажиллах зэрэгт суралцдаг.



Онцгой байдлын дасгал сургуулалтыг ослын зэрэглэлээр нь 3 төвшинд ангилдаг. Үүнд:

- Төвшин 1 (өөр өөр давтамжтай янз бүр) – хээрийн ангийн хүрээнд
- Төвшин 2 (жилд 1 удаа) – тухайн улсын хэмжээнд буюу “Бадрах Энержи” компанийн төв оффис, хээрийн ангийн хүрээнд
- Төвшин 3 (гурван жилд 1 удаа) – Орано Майнинг, “Бадрах Энержи” болон хээрийн ангийн хүрээнд.

	2021	2022
Төвшин 1	2	2
Төвшин 2	1	1
Төвшин 3	0	1



Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ

Гэнэтийн осол, байгалийн гамшиг тохиолдоход бэлтгэлтэй байх зорилгоор холбогдох төр захиргааны байгууллагуудтай хамтран онцгой байдлын арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан, мөрдөж ажилладаг. Уг төлөвлөгөөг Орано групп болон холбогдох төр захиргааны байгууллагын мэргэжилтнүүд нямбай боловсруулж, жил бүр хянан, шаардлагатай тохиолдолд шинэчилдэг. Манай компанийн шуурхай ажиллагааны баг байнгын

Онцгой байдлын үеийн зохион байгуулалт

“Бадрах Энержи” компанийн шуурхай ажиллагааны баг нь аливаа тохиолдолд дүн шинжилгээ хийж, шийдвэр гаргах өндөр чадвартай ажилтнуудаас бүрддэг. Мөн онцгой нөхцөл байдал эсвэл хямрал үүсвэл компанийн байгууламжуудыг аюулгүй болгож, тухайн тохиолдлын нөлөөллийг бууруулах, дотооддоо болон олон нийтэд мэдээлэх зэрэг шаардлагатай бүх арга хэмжээг авч ажилладаг. Шуурхай ажиллагааны багийн үр чадварыг үнэлэх зорилгоор орон нутгийн болон төр захиргааны төв байгууллага, орон нутгийн онцгой байдлын багуудтай хамтран тодорхой түвшний дасгал сургуулалтыг тогтмол зохион байгуулахыг зорьдог.



2022 онд хийсэн онцгой байдлын үеийн сургуулалт

3-р төвшин

“Бадрах Энержи” компани 2022 оны 7 дугаар сард Орано Майнинг компанитай хамтарч Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтын талбайд 3-р төвшний бүрэн хэмжээний онцгой байдлын үеийн сургуулалтыг зохион байгуулсан. Уг сургуулалтад Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтын удирдлагын баг, Улаанбаатар хот дахь бус нутгийн удирдлагын баг болон Франц дахь төв оффисын ослын удирдлагын багууд оролцсон.

Уг сургуулалтыг гуравдагч этгээд үйлдвэрт зөвшөөрөлгүй нэвтэрсний улмаас ажилтан химийн бодисын асгаралтад өртөж, гэмтсэн гэх тохиолдлын зохиомжоор хийв. Тус сургуулалтыг зохиомжит тохиолдол дээр хариу арга хэмжээ хэрхэн авч байгаад бодит үнэлгээ өгч, засаж сайжруулах арга хэмжээг төлөвлөж ажиллах үндсэн зорилгоор гүйцэтгэлээ.

1-р төвшин

Гурван удаагийн төвшин-1-ийн онцгой байдлын дасгал сургуулалтыг урьдчилан төлөвлөсөн төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэсэн ба сургуулалтад компанийн ажилтнуудаас гадна гэрээлэгч “Империал Секьюрити” ХХК, “Адэн Сервисэс” ХХК-ийн ажилтнууд оролцсон. Сургуулалтад гал унтраах, унтраагуурын дагалдах хэрэгслийг ашиглах мөн онцгой байдлын үед цугларах цэг дээр шуурхай цугларах зэргийг багтаасан. Сургуулалтад нийт 78 ажилтан хамрагдав.



5 | ЭРҮҮЛ МЭНД, АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЦАЦРАГ ХАМГААЛАЛ



УУЛ УУРХАЙН ЗАРЧИМ

Осол гэмтлийн зэргийг ТЭГ байлгах зорилго тавьж эрүүл мэнд, аюулгүй байдлын гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулах.

Эрүүл мэнд, аюулгүй байдал, цацраг хамгааллын бодлого

“Бадрах Энержи” компани үндсэн болон гэрээт ажилтнуудаа эрүүл, аюулгүй ажиллах орчин нөхцөлөөр хангаж, гүйцэтгэж буй ажил, ажлын үйл явц нь хууль дүрэм мөн компанийн норм стандартын дагуу хариуцлагатай, аюулгүй хийгдэж байгааг хангах үүрэг хүлээдэг.

Бид эрүүл мэнд, аюулгүй байдал, цацраг хамгааллын удирдлагыг хэрэгжүүлэхдээ эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах ажлын гүйцэтгэлийг тасралтгүй сайжруулан, осол гэмтлийн зэргийг тэг байлгах эцсийн зорилготой ажилладаг.

I Хэмжилт, үнэлгээ

“Бадрах Энержи” ХХК Орано группийн эрүүл мэнд, аюулгүй байдал, цацраг хамгааллын бодлогыг мөрддөг. Уг бодлого нь Монгол Улсын стандарт мөн бусад дүрэм журмын шаардлагад нийцсэн байдаг.

Манай компани Орано группийн аюулгүй байдлын 5 зарчим, 7 стандартыг нэвтрүүлж ажилласнаар эрсдэлийг удирдах, аюул ослоос урьдчилан сэргийлэх шилдэг туршлагаудыг хэрэгжүүлж байна.

Компанийн аюулгүй байдлын 5 зарчим, 7 стандарт

Эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны системийн үр дүнг хэмжих арга зүйд дараах багтдаг. Үүнд:

- “Бадрах Энержи” компанийн ажилтнууд аливаа ажлын өмнө дотоод аудит хийх,



- Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн байцаагчдын төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалт, хөндлөнгийн аудит хийх,
- Компанийн эрүүл мэнд, аюулгүй байдал, цацраг хамгааллын хорооны хурал, шийдвэр: удирдлагаас ХАБЭМ, цацраг хамгааллын гүйцэтгэл, хяналт шалгалтын үр дүн, үл нийцэл, мэдээлэл харилцаа болон нөхцөл байдлын өөрчлөлт зэргийг хэлэлцэх,
- АHEAD систем – Орано группийн цөмийн аюулгүй байдал, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, цацраг хамгаалал, тээвэрлэлт, хүрээлэн буй орчны талаар дотоод мэдээлэл, мэдэгдэл дамжуулах систем,
- Засгийн газрын холбогдох байгууллагад жил бүрийн тайлан гаргаж хүргүүлэх,
- ХАБ-ын өдөрлөгөөр гүйцэтгэлийн үнэлгээ хийх зэрэг багтдаг.

Эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны хэмжилт, үнэлгээний ерөнхий арга зүйд дараах зүйлс багтдаг. Үүнд:

- Хээрийн анги дахь эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны өдөр тутмын уулзалт хурал,
- Ажилтнуудын аюулгүй байдлын зан төлөв идэвхтэй байгаа эсэхэд анхаарах,
- 2020 оноос бид үйл ажиллагаанд гарч болох аюулгүй ажиллагааны алдаа, зөрчлийг илрүүлж, хянах зорилгоор ХАБ-ын Парето хяналтын самбарыг байршуулж, MVP буюу ХАБ-ын удирдлага, гүйцэтгэлийн үзүүлэлтийг сайжруулан ажиллаж байна. Үүний дагуу ажилчдын оролцоог хангах,
- Ажил бүрийн өмнө дотоод эрсдэлийн үнэлгээ хийх,
- Ажилтнуудаар аюулгүй ажиллагааны үзлэг шалгалтыг тогтмол хийлгүүлэхэд чиглэсэн “Аюулгүй ажиллагааг оролцооны аргаар шалгах” буюу VSP (Participative Safety Visits), “Ажлын талбай дахь менежер” буюу MIF (Manager in the Field) хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх.
- ХАБ-ын багаас ажлын АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ АЖИГ ЛАХ хөтөлбөрийг хэрэгжүүлэх,

- Одоо болон ирээдүйд ноцтой гэмтэл бэртэл, амь нас эрсэдсэн осол гарах эрсдэлийг бууруулах зорилгоор тухайн тохиолдлын нарийвчилсан судалгааг хийж, засах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх,
- Шуурхай мэдээ – Орано группийн салбар компаниудын аюулгүй ажиллагааны мэдээллээс судалж, хуваалцах, аюулгүй байдлын зарчимд үндэслэн ноцтой асуудлуудыг тодорхойлох,
- Хөдөлгөөний урсгалын хяналт – Бүх тээврийн хэрэгсэлд суурилуулсан GPS систем бүхий машин механизмын удирдлагын программ хангамж (“Гайхам”) нь тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнийг бодит цаг хугацаанд хянаж, хурдны хязгаарыг хангуулах чухал хэрэгсэл юм,
- Үл нийцлийг илрүүлэх, хянах, засах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх зэрэг аюулгүй ажиллагааны хэмжилт, үнэлгээний ерөнхий арга зүйг ашиглаж байна.

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

Ажил амьдралын тэнцвэр

Компани жил бүр эрүүл мэнд, аюулгүй байдлыг байнга сайжруулахын тулд зорилго, зорилтыг дэвшүүлэн харилцан хамаарал бүхий ХАБ-ын соёлыг нэвтрүүлэхийг зорин ажилладаг. Эдгээр зорилго, зорилт нь Орано группийн эрүүл мэнд, аюулгүй байдлын бодлого болон Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль, Мэргэжлээс шалтгаалах эрүүл мэнд, аюулгүй байдлын тухай хуулиар хүлээсэн үүрэг амлалтын нэг байдаг.

I ХАБ-ын үзүүлэлт

	2021	2022
Амь нас эрсэдсэн	0	0
Ажлын зогсолттой бэртэл, гэмтэл	0	0
Эмнэлгийн тусламж авсан бэртэл, гэмтэл	1	1
Анхны тусламж	0	0
Осолд дөхсөн тохиолдол – Сул дохио	3	6

Тайлант хугацаанд ажлын зогсолттой ноцтой осол бүртгэгдээгүй бөгөөд 2022 оны эцсийн дүнгээр ажлын зогсолттой осол гаргалгүй нийт 931 хоног ажиллаж байна. Манай компани дээр бүртгэгдсэн тохиолдол тус бүрийг нарийн судалж, дүн шинжилгээг хийж, мэдээлж ажилласан.

I Ноцтой гэмтэл бэртэл, эрсдэл бүхий ослыг илрүүлэх

“Бадрах Энержи” компани өөрийн үйл ажиллагаан дахь аливаа үл нийцэл, осолд дөхсөн мөн өндөр эрсдэл бүхий тохиолдлыг илрүүлж, шийдвэрлэсээр байна. Компанийн захирал, менежер, ажилтнууд хээрийн ангид хийгдэж байгаа хяналт шалгалтын зэрэгцээ тухайн жилд гарсан өндөр эрсдэл бүхий тохиолдын шинжилгээнд оролцдог.

НИРО буюу өндөр эрсдэл бүхий тохиолдол

Өндөр эрсдэл бүхий тохиолдол бүрийг бүртгэж, шалтгааныг судлан шинжилдэг. Судлан шинжлэх ажлын тайланг ХАБ болон холбогдох багууд хамтран боловсруулж, компанийн болон гэрээлэгч компанийн ажилтнуудад мэдээлж, засан сайжруулах төлөвлөгөөг гаргадаг.

Өндөр эрсдэлтэй ослыг:

- SIF- ноцтой гэмтэл, нас баралт,
- Өөр нэг чухал үйл явдал,
- Осолд дөхсөн тохиолдол гэж ангилдаг.

2020–2022 онд “Бадрах Энержи” компанид 6 өндөр эрсдэл бүхий тохиолдол бүртгэгдсэн. Тэдгээрийн тал гаруй нь цахилгааны хэрэгсэлтэй ямар нэгэн холбоотой байв. Бүртгэгдсэн өндөр эрсдэлтэй тохиолдол бүрээр шинжилгээ хийж, шаардлагатай үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэхдээ үл нийцэл бүрийг цаг тухайд нь засаж залруулсан.

Осолд дөхсөн тохиолдлыг цаг алдалгүй мэдэгдэх нь осол, гэмтлээс урьдчилан

сэргийлэхэд чухал ач холбогдолтой. Бид компанийн ажилтан бүрийг эрүүл мэнд, аюулгүй байдал, цацраг хамгааллын талаарх аливаа үл нийцлийг мэдэгдэхийг уриалдаг.

Осол дөхсөн тохиолдлын талаар мөн өглөөний “ХАБ–ын таван минут” хурлаар танилцуулдаг. Ийнхүү ХАБ–ын баг осол, ноцтой осол гарахаас урьдчилсан сэргийлэхэд хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

I ХАБ-ын менежмент, мэдлэгээ бэхжүүлэх сургалт

Компанийн хэмжээнд ХАБЭМ, аюулгүй байдлын ач холбогдлыг сануулах, тэмдэглэх зорилгоор бид ХАБ–ын мэргэшсэн сургалтын төвтэй хамтарч жил бүр сургалтуудаа зохион байгуулдаг. Сургалтад компанийн төдийгүй гэрээлэгч аж ахуйн нэгжүүдийн ажилтнууд хамрагддаг. 2022 оны 6 дугаар сарын сургалтаар өндөр эрсдэл бүхий тохиолдлыг хэрхэн бүртгэлжүүлэх, ямар арга аргачлалаар дүн шинжилгээ хийх, засах төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх тухай онцлон ярилцаж, суралцлаа.

Компанийн хээрийн ангид цацрагийн хяналтын бүсэд ажилладаг ажилтнууд Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл мэндийн төвд жилд 2 удаа үзлэгт ордог журамтай.

Хээрийн ангийн эмч эрүүл мэндийн дараах зөвлөгөө, тусламж үйлчилгээ үзүүлдэг. Үүнд:

- Ажилтнуудын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- Эрүүл мэнд, эрүүл ахуйн мэдлэг сайжруулах сургалт зохион байгуулах
- Эрүүл мэндийн хугацаат үзлэг зохион байгуулах, хяналт тавих
- Сайн дурын дархлаажуулалтын ажил зохион байгуулах
- Эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх
- Хүнсний аюулгүй байдал эрүүл ахуйн хяналтыг хийх зэрэг сэдвээр зөвлөгөө, тусламж үзүүлэн ажиллаа.

Компани ажилтнуудаа гэр бүлийн гишүүдийнх нь хамт эрүүл мэндийн нэмэлт даатгалд хамруулдаг.



ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

Орано группийн бүх салбар компаниуд ХАБ–ын өдөрлөгийг зохион байгуулдаг. Өдөрлөгөөр бүх гэрээлэгч компаниудын хамт ХАБ–ын ач холбогдол, чухлыг дахин санахын зэрэгцээ ХАБ–ын соёлоо бататган харуулдаг билээ.

ОНЦЛОХ НЬ

Химийн бодисын эрсдэлийн менежментийн сургалтыг 2021–2022 онд зохион байгуулсан ба Зөвөч–Овоо үйлдвэрлэлийн туршилтын үеэр жил бүр химийн бодисын эрсдэлийн сургалтыг зохион байгуулсан.

I Эрүүл мэндийн бодлого

“Бадрах Энержи” компани бүх ажилтнуудаа хөдөлмөрийн эрүүл мэнд, ариун цэврийн стандартын шаардлага, нөхцөл хангасан эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамруулдаг. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн Сонгдо эмнэлэгт ажилтнуудаа жил бүр эрүүл мэндийн үзлэг, хяналтад хамруулж, ажилтнуудын эрүүл мэндийг хянадаг. Үүний зэрэгцээ компанийн эмч ганцаарчилсан зөвлөгөө өгч ажилладаг.

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

“Бадрах Энержи” компани Сонгдо эмнэлэгтэй эмнэлгийн яаралтай нүүлгэн шилжүүлэх үйлчилгээ үзүүлэх, өвчтөнийг газраар болон агаарын тээврээр нүүлгэн шилжүүлэх ажилд туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан ажилладаг.

I Цацраг хамгаалал

“Бадрах Энержи” компани үндсэн болон гэрээт ажилтнууд, орон нутгийн иргэдийг цацрагийн эрсдэлээс хамгаалахын тулд цацраг хамгааллын олон арга хэмжээ авч хэрэгжүүлдэг. Тухайлбал, компанийн байгууламж дахь ажилтнуудын ионжуулагч цацрагт өртөх эрсдэлийг аль болох бага хэмжээнд байлгах зорилгоор нарийвчилсан судалгааг хийснээр цацрагийн өртөлтийн хугацааг хязгаарлах, хувийн хамгаалах хэрэгслээр хангах зэргийг тусгасан үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, цацрагийн аюулгүй ажиллагааны дүрмийг хэрэгжүүлдэг. Компанийн цацраг хамгааллын хөтөлбөрийг Монгол Улсын Цөмийн энергийн тухай хуулийн дагуу Цөмийн энергийн комиссоос хянан баталгаажуулдаг.

Ажилтнуудын мэргэжлийн шарлагын нэмэлт тунгийн хяналт

“Бадрах Энержи” компаниас	54 ажилтан
Гэрээлэгч аж ахуйн нэгжээс	7 ажилтан
Нийт	61 ажилтан

> 0 болон < 2 мЗв	59
> 2 болон < 4 мЗв	2
> 0 болон < 1 мЗв	35

	2021	2022
Шарлагын дундаж тун	0.46	0.9
Шарлагын хамгийн их тун	2.29	2.43
Монгол Улс, олон улсын стандарт цацрагтай ажиллагчийн нэг жилийн тунгийн хязгаар	20	20



I Цацрагийн шарлагын хяналт

Цацрагийн хяналтын хөтөлбөрийн дагуу дараах цацрагийн хяналтыг хэрэгжүүлдэг. Үүнд:

- Компанийн хээрийн ангид хоёр долоо хоног тутам тогтсон цэгт нэг удаа цацрагийн хэмжилт хийдэг.
- Хүрээлэн буй орчны цацрагийн хэмжилтийг мөн улирал тутамд хийдэг.
- Тусгай зөвшөөрлийн талбайн тодорхой цэгүүдэд хөрс, усны цацрагийн түвшинд хяналт хийж, дээж авч шинжлүүлдэг.
- Тодорхой байршуулах альфа дозиметр байршуулж, хянадаг.
- Ажилтны дотоод, гадаад шарлагын тунг хэмждэг.

Зөвөч–Овоо үйлдвэрлэлийн туршилтын үеэр орон нутгийн хүн амын цацрагт өртөх эрсдэлд хийсэн хяналтаар компанийн үйл ажиллагаанаас цацрагийн нэмэлт нөлөөлөл үүсээгүй болохыг баталсан.

ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

“Бадрах Энержи” компани Сонгдо эмнэлэгтэй эмнэлгийн яаралтай нүүлгэн шилжүүлэх үйлчилгээ үзүүлэх, өвчтөнийг газраар болон агаарын тээврээр нүүлгэн шилжүүлэх ажилд туслалцаа үзүүлэх гэрээ байгуулан ажилладаг.

I Цацраг хамгааллын сургалт

Хяналтын бүсэд ажиллаж байгаа ажилтан бүр цацраг хамгааллын сургалтад хамрагдах ёстой. Цөмийн энергийн тухай хуулийн дагуу уг сургалтыг хоёр жилд нэг удаа зохион байгуулдаг. Хяналтын бүсэд ажиллаж байгаа гэрээлэгч аж ахуйн нэгжийн ажилтнууд ч мөн тус сургалтад хамрагддаг.

6 | БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮЗҮҮЛЭЛТ



УУЛ УУРХАЙН ЗАРЧИМ

Усны нөөцийн удирдлага, эрчим хүчний хэрэглээ, уур амьсгалын өөрчлөлт зэрэг байгаль орчны чиглэлээр хүлээсэн үүргээ тасралтгүй биелүүлж сайжруулах

Байгаль орчин хамгаалал

I Бодлого

Үйл ажиллагааныхаа үе шат бүрт байгаль орчин хамгаалах үүргээ биелүүлэх нь манай хамт олны амжилт, тогтвортой хөгжлийн гол түлхүүр болдог.

Уул уурхайн компаниуд уурхайн ашиглалтын хугацаанд дэд бүтэц байгуулж, түүхий эд, нөөц материал, тэр дундаа ус, эрчим хүч ашигладаг. Үүнээс байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг үнэлж, хяналт шинжилгээ хийн, бууруулах арга хэмжээ авч ажилладаг.

2022 онд “Бадрах Энержи” компани Монголын уул уурхайн үндэсний ассоциаттай Хариуцлагатай уул уурхайн кодексыг байгуулж олон улсын шилдэг стандартыг хэрэгжүүлэх амлалт үүргээ дахин батлан, байгаль орчин хамгааллын талаар үлгэр жишээ ажилладаг илтгэв.

“Бадрах Энержи” ХХК 2021–2022 онд Зөвч–Овоо ГДУО үйлдвэрлэлийн туршилтыг явуулахаас өмнө байгаль орчин, нийгмийн болон эрсдэлийн үнэлгээ, судалгааг хийсэн.

Манай компани Монгол Улсын хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн сацуу Орано группийн шилдэг туршлагаас нэвтрүүлж, компанийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх, хамгаалах үүргээ дараах байдлаар хэрэгжүүлж байна. Үүнд:

- Байгаль орчин, технологийн бүх төрлийн эрсдэлийг тодорхойлж сэргийлэх,
- Компанийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах,
- Эрчим хүч, байгалийн нөөцийг хэрэглээг багасгаж, биологийн төрөл зүйлийг хамгаалж, хаягдлын хэмжээг хянан, хог хаягдлын менежментийг оновчтой болгох,

- Биологийн олон янз байдлыг хадгалах, хамгаалах
- Байгаль орчны бүрдэлд үзүүлэх нөлөөллийг тодорхойлж үнэлэх, бууруулах арга хэмжээ авч, хянахын зэрэгцээ засах, нөхөн сэргээх арга хэмжээг хэрэгжүүлж, гэнэтийн нөхцөл байдлын үеийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх,
- Байгаль орчин хамгаалахад төслийн оролцогч талууд, тухайлбал компанийн ажилтнууд, нутгийн иргэд, гэрээлэгч компани болон эрх бүхий байгууллагуудыг татан оролцуулж, мэдээлэл өгч ажиллаж байна.

ОНЦЛОХ НЬ

Компани үйл ажиллагаа эрхлэхийн өмнө дараах зөвшөөрлийг авдаг. Үүнд:

- Байгаль орчны менежментийн төлөвлөгөө
- Цацрагийн хамгаалалт, аюулгүй ажиллагааны дотоод дүрэм
- Усны дүгнэлт– ус ашиглах гэрээ
- Хог хаягдлын менежментийн гэрээ
- Галын дүгнэлт
- Химийн бодисын зөвшөөрөл
- Цөмийн бодис эзэмших, ашиглах зөвшөөрөл.

I Үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл

“Бадрах Энержи” компани үйл ажиллагаагаа явуулахдаа Монгол Улсын Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Боловсрол, шинжлэх ухааны яам, Усны газар, Галба өөш долоодын говийн усны ай сав газрын захиргаа, Онцгой байдлын ерөнхий газраас холбогдох зөвшөөрөл авдаг. Эдгээр байгууллагууд нь жил бүрийн үйл ажиллагаа явуулах нөхцөл болох зөвшөөрөл олгодог. Мөн үйл ажиллагааны хөтөлбөрийг хянан баталж, хяналт шалгалт хийснээр



“Бадрах Энержи” компани амлалт, үүргээ биелүүлж байгааг баталгаажуулдаг.

Компанийн ХАБЭМ, цацраг хамгаалал, байгаль орчны баг нь байгаль орчны хөтөлбөр, төлөвлөгөө нь хууль, дүрмийн шаардлагад нийцсэн, тасралтгүй, зохих ёсоор хийгдэж байгааг хангахын зэрэгцээ мэргэжлийн агентлаг, байгууллагуудтай нягт хамтран ажилладаг.

Уурхайн мөчлөг бүр дэх байгаль орчны судалгаа

“Бадрах Энержи” компани хайгуулаас олборлолтын үйл ажиллагааны үе шат бүртээ байгаль орчны судалгаа, шинжилгээг хийж ирсэн. Үүний сацуу үйл ажиллагаа явуулж байгаа орчин нөхцөлийн онцлог, экосистемийг сайтар таньж мэдэх зорилгоор нэмэлт нарийвчилсан судалгааг мөн хийдэг.

I Заавал гүйцэтгэх судалгаа, шинжилгээ

Суурь судалгаа – Төлөв байдлын судалгаа

Уул уурхайн төсөл хэрэгжүүлэхэд байгаль орчны төлөв байдлын судалгаа чухал ач холбогдолтой ба уг судалгааг төсөл эхлэхийн өмнө хийдэг. “Бадрах Энержи” компани Зөвч–Овоо үйлдвэрлэлийн туршилтын төсөл эхлүүлэхийн өмнө байгаль орчны төлөв байдлын судалгааг хийсэн. Тус судалгааг 2012 онд анх хийж байсан бол 2020 онд дахин шинэчлэн гүйцэтгэв.



Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ

Төлөв байдлын судалгаа хийсний дараа БОАЖЯ Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийж, төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх эсэхийг шийдэж, байгаль орчин хамгааллын талаар холбогдох зөвлөмж, шаардлагыг ирүүлдэг. 2020 онд гүйцэтгэсэн Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээгээр Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтын хувьд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийх зөвлөмж гарсан.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ нь аливаа төслийн нөлөөллийн үндсэн судалгаа бөгөөд төслийн талбайн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний удирдамж болохоос гадна талбай орчмын байгаль орчны талаар (биологийн олон янз байдлын тооллого, бүс нутгийн нийгэм, эдийн засгийн байдал гэх мэт) дэлгэрэнгүй ойлголтыг өгч, эрсдэлийг эх үүсвэр нь дээр бууруулах, урьдчилан сэргийлэх, хамгаалах бүх арга хэмжээг тодорхойлсон байдаг. Уг үнэлгээд байгаль орчинд учрах бүх томоохон нөлөөг судлан тодорхойлдог. Тэдгээрийг бууруулах, арилгах, хянах үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлдэг төдийгүй дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг ч мөн санал болгодог. Нарийвчилсан үнэлгээнд уурхайн ашиглалтын хугацааны төгсгөл үе шатанд хэрэгжүүлэх нөхөн сэргээлт, байгаль орчны хяналт шинжилгээний төрөл, зарчмуудыг мөн багтаадаг.

Нарийвчилсан үнэлгээг эрх бүхий байгууллагаар хянан батлуулж, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу олборлолтын үйл ажиллагааны дараа уурхайн хаалтын төлөвлөгөө хэрэгжүүлэх баталгаа болгож жил бүр байгаль орчны барьцаа мөнгийг тусгай дансанд байршуулдаг.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу 5 жил тутамд шинэчилж, үйл ажиллагаанд гарсан өөрчлөлт, нийгмийн байдал, мөн байгаль орчныг хамгаалах технологийн шинэчлэлийг тусгадаг. Түүнчлэн, байгаль орчинд илэрсэн асуудал, төслийн байгууламжийн барилга угсралт эсвэл үйл ажиллагааны шат дамжлагад гарсан өөрчлөлт, төслийн цар хүрээ, хэрэгжих хугацаанд хийгдсэн тодотгол, шинжлэх ухаанд гарсан ололт амжилт, эсвэл хууль, дүрмийн шаардлага зэргийг тусгадаг. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт,

тодотголоор байгаль орчинд томоохон нөлөө үзүүлж болохуйц нөхцөл байдал тогтоогдвол түүнийг бууруулах, арилгах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлдэг.

Иргэдийн хэлэлцүүлэг

Нутгийн оролцогч талыг төсөл хөгжүүлэлтийн нэг хэсэг гэж үздэг тул байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний шатанд орон нутгийн иргэдэд мэдээлэл өгч, хэлэлцүүлэг зохион байгуулдаг. Нутгийн иргэдэд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөлөл, түүнээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний талаар шаардлагатай бүх мэдээ, мэдээллийг өгч, санал шүүмжлэлийг нь сонсож, үнэлгээний тайланд тусгадаг.

“Бадрах Энержи” компани Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтын төслийг эхлүүлэхийн өмнө 2020 онд нутгийн иргэдтэй гэрээр нь уулзах, багийн хурлаар мэдээлэл өгөх, мөн хэзэрийн ангид уулзалт зохион байгуулах зэргээр уулзалт, хэлэлцүүлгийг биөчлэн зохион байгуулж ажилласан.



ОНЦЛОХ НЬ

Өнөөдрийн байдлаар “Бадрах Энержи” компанийн үйл ажиллагаанд хамаарах гурван удаагийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг эрх бүхий мэргэжлийн байгууллага хийж гүйцэтгээд байна.

- 2010 онд Өмнөтийн төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ
- 2015/2016 онд Зөвч-Овоо төслийн байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийснийг 2020/2021 онд нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Бусад нэмэлт судалгаанууд

- Газрын хянан баталгаагаар холбогдох талбайн газрын чанарыг үнэлдэг. Үүгээр болзошгүй нөлөөг тодорхойлж, нөхөн сэргээхэд шаардлагатай арга хэмжээний зөвлөмжийг өгдөг. Уг судалгаагаар олборлолтын орчмын бэлчээрт үзүүлэх нөлөөг ч хянах боломжтой болдог. Газрын хянан баталгааны судалгааг таван жил тутамд хийдэг. Манай компани газрын хянан баталгааны судалгааг сүүлд 2020 онд хийж баталгаажуулсан бөгөөд дараагийнхыг 2025 онд хийж гүйцэтгэнэ.
- Байгаль орчны аудитыг тусгай зөвшөөрөл бүхий хараат бус мэргэжлийн байгууллага хийж гүйцэтгэдэг. “Бадрах Энержи” компанийн үйл ажиллагаанд байгаль орчны аудит сүүлд 2021 онд орж, 99 хувийн гүйцэтгэлийн үнэлгээ авсан. Байгаль орчны аудитаар нийцлийн талаарх удирдамжийг өгдөг.
- Археологи, палентологийн судалгааг холбогдох хууль, дүрмийн дагуу хийж гүйцэтгэн палентологийн хувьд ач холбогдолтой байх магадлалтай талбайг буцаагаад байна.

ОНЦЛОХ НЬ

Нэмэлт судалгаа

- Экологийн эрсдэлийн үнэлгээ нь төслийн ойр орчмын ан амьтанд нөлөөлж болзошгүй төслийн эрсдэлийг үнэлдэг. “Бадрах Энержи” ХХК нь энэ судалгааг 2016 онд хийсэн.
- Цацрагийн эрсдэлийн үнэлгээг Зөвч-Овоо ГДУО үйлдвэрлэлийн туршилтын ажил эхлэхээс өмнө болон туршилт үргэлжлэх хугацаанд хийж гүйцэтгэсэн. Энэ судалгаа нь байгалийн цацрагийн дэвсгэр тунгийн зураглалыг гаргах замаар цацрагаас байгаль орчин, хүн амд үзүүлэх нөлөөг тодорхойлох зорилготой байдаг. Энэ судалгааг 2024 онд хийхээр төлөвлөсөн бөгөөд энэ нь Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтаас өмнөх, туршилтын хугацаанд болон туршилтын дараа гарсан үр дүн, мэдээллийг харьцуулах зорилготой.
- Химийн эрсдэлийн үнэлгээ нь БОННУ-ний нэгэн хэсэг бөгөөд Зөвч-Овоо ГДУО үйлдвэрлэлийн туршилтын төсөлд зориулж тусад нь хийсэн.
- Малчдын худгийн өгөгдлийн шинжилгээ. Манай компани жил бүр олон тооны малчдын худгаас хяналтын мэдээлэл авдаг. “Бадрах Энержи” компани нь хэд хэдэн бие даасан шинжээчтэй хамтран цуглуулсан мэдээллийг шинжилж, дүгнэлт гарган орон нутгийн иргэдэд тайлагнадаг. Хамгийн сүүлд гүйцэтгэсэн шинжилгээний үр дүн нь 2014–2018 оныг хамарсан бол дараагийнх нь 2018–2022 оныг хамарсан бөгөөд 2023 онд дүгнэлтийг нь танилцуулахаар төлөвлөсөн.
- Хөхтөн амьтан, шувууны судалгааг Зөвч-Овоо ГДУО үйлдвэрлэлийн туршилтын БОННУ-нд тусгасны дагуу “Бадрах Энержи” компани энэ судалгааг эхлүүлж, шаардлагатай бүх мэдээллийг цуглуулсан. Энэ судалгаа нь дараагийн БОННУ-нд маш чухал ач холбогдолтой ба ирээдүйд бусад мэдээлэлтэй харьцуулна.
- Дорноговь аймгийн Засаг даргын хүсэлтийн дагуу хөндлөнгийн мэргэжлийн байгууллагаар усны аудит хийлгэхэд

Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтад ашигласан ГДУО технологиос нөлөөлөл үзүүлээгүйг тогтоосон.

Уул уурхайн стандартын нийцэл

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө, хяналт

Зарчим

Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчны хяналт мониторингийн үндсэн бичиг баримтын нэг юм. Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний дүгнэлтэд байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зарчим, чиглэлийг тусгадаг ба компанийн тухайн жилийн үйл ажиллагаатай шууд уялдаатай байдаг.

Жил бүр байгаль орчны хяналт шинжилгээ, менежментийн төлөвлөгөөг боловсруулж, БОАЖЯ-аар хянан батлуулдаг. Төлөвлөгөөний хэрэгжилтийг орон нутгийн байгаль орчин, аялал жуулчлалын газар хянасаар ирлээ.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд гадаргын болон гүний усны хяналт, хөрс агаарын чанарын хяналт, гидрогеологийн хяналт мониторинг, нөхөн сэргээлтийн хөтөлбөр, биологийн олон янз байдлын хамгаалал зэргийн хяналтын асуудлыг тусгах ба үүгээр хязгаарлагдахгүй болно.

Байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүдэд хийх шинжилгээний төрөл, давтамж, арга аргачлалыг уг төлөвлөгөөнд мөн тусгадаг. Үүний зэрэгцээ, манай компани төлөвлөгөөнд тусгасан ажил, түүний хэрэгжилт, үр дүнгийн талаар сум, орон нутгийн иргэдэд тогтмол мэдээлэл үүрэг хүлээдэг.

Жилийн эцэст орон нутгийн байгаль орчны хэлтсээс байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг дүгнэдэг.

Манай компани жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтээ дараах байдлаар үнэлүүлж ирлээ. Үүнд:

- 2020 он: 90,1 оноо
- 2021 он: 91,5 оноо
- 2022 онд 93,3 оноо тус тус авсан байна.

Хяналт мониторинг

Уул уурхайн компанийн хувьд байгаль орчны хяналт өндөр ач холбогдолтой бөгөөд хяналтын үр дүнг байгаль орчны суурь судалгааны үр дүнтэй харьцуулан хянадаг.

Хяналтын хөтөлбөрийг боловсруулахдаа байгалийн бүрэлдэхүүн болох хөрс, агаар, ургамал, амьтан, ус зэрэгт хийх шинжилгээний төрөл, давтамжийг тодорхой зааж өгдөг.

Байгаль орчны хяналт шинжилгээг дараах арга зүйн дагуу гүйцэтгэнэ. Үүнд:

- Компанийн үйл ажиллагааны улмаас байгаль орчинд учирч болзошгүй нөлөөлөл бүрийг тодорхойлох
- Хэзэрийн судалгаа хийж, дээж авах
- Байгаль орчин бохирдуулах эрсдэлүүдээс сэргийлэх, хамгаалах зохих арга хэмжээ авах
- Хяналт шинжилгээ хийж, шинжилгээний үр дүнд тайлбар өгөх, дүгнэлт боловсруулах, тайлагнах
- Шинжилгээний үр дүнг боловсруулж, зөвлөмж, дүгнэлт гаргах
- Байгаль орчин хамгаалахад чиглэсэн хамтарсан хяналт шинжилгээ хийж, орон нутгийн иргэдийг мэдээллээр хангах
- Тайлан гаргах зэргээр байгаль орчны хяналт шинжилгээг хийж гүйцэтгэдэг.

Усны хяналт шинжилгээ компанийн үйл ажиллагааны гол цөм

Арга зүй

Орано Майнинг компани нь Дэлхийн нөөцийн хүрээлэнгийн арга зүйн дагуу олон оронд ажиллаж байгаа арван салбар компанийнхаа хүрээнд “Aqueduct Water Risk Atlas” буюу усны эрсдэлийн атласын дагуу усны ачааллын түвшинд үнэлгээ өгдөг.



Уг үнэлгээгээр дараах эрсдэлийг ялган авч үздэг. Үүнд:

- Тоо хэмжээтэй холбоотой биет эрсдэл, үүнийг дараах 8 үзүүлэлтээр үнэлнэ: усны ачаалал, ус шавхагдах, жил бүрийн өөрчлөлт, улирал бүрийн өөрчлөлт, уст үеийн түвшин буурах, гол үерлэх, эрэг үерлэх болон ган гачгийн эрсдэл. Усны хүртээмжийн эрсдэлийг үнэлдэг, чанартай холбоотой биет эрсдэл нь усыг хэрэглэж болох эсэхийг үнэлдэг ба дараах хоёр үзүүлэлтийн дунджаас тооцдог: бохир ус цэвэрлэх байгууламжтай холбогдсон эсэх болон эрэг орчмын усны аажмаар эрдэсжих явц.
- Хууль журмын болон нэр хүндийн эрсдэл, үүнд орон нутгийн байгууллагын усны менежменттэй холбоотой эрсдэл (ундны ус, усны эрүүл ахуй), мөн олон нийттэй усны хүртээмжээс болж үүсэх маргаан.



талаарх усны нөөцийн менежментийн шаардлагуудыг хэрэгжүүлэхийг зорьдог.

Ус бол компанийн үйл ажиллагаа явуулдаг Монголын говь цөлийн бүсийн хүн амын ахуй амьдралд зайлшгүй шаардлагатай байгалийн нэн үнэт нөөц билээ. Жилийн дөрвөн улиралд мал аж ахуй эрхлэн аж төрдөг ард иргэдийн хувьд усны чанар нь эн тэргүүний санаа тавих асуудал юм.

Уул уурхайн үйл ажиллагаа нь усны нөөцийн хэмжээнд төдийгүй чанарт ихээхэн нөлөө үзүүлэх магадлалтай байдаг.

Газар доор уусган олборлох технологийг ашиглах үед байнгын анхаарах сэдвийн нэг нь ус тул компани усны бүрэн хяналт шинжилгээний хөтөлбөрөө Монгол Улсын стандарт, хууль, журамд нийцүүлэн хэрэгжүүлснээр олборлолтын өмнөх үеийн усны нөөцийн хэмжээ, чанар өөрчлөгдөөгүйг баталгаажуулж ирсэн.

“Бадрах Энержи” ХХК нь зэрэгцээ компани болох “Кожегов” ХХК-ийн хийсэн хайгуулын ажлын үеэс усны менежмент, хяналтад анхаарч ажиллаж ирсэн билээ. Ингэхдээ геологи, гидрогеологи, газрын доорх усны судалгааг хийж ирсэн нь Монгол улсын гидрогеологийн судалгааны түүхэнд хамгийн өргөн цар хүрээтэй төслүүдийн нэг болсон юм.

Компанийн байгаль орчин, гидрогеологийн багийнхан хууль, журмын дагуу усны хяналтыг цаг тухайд нь гүйцэтгэх зорилготой ажиллаж байна. Үүнд хяналтын цооноогоор дамжуулан газрын доорх усны чанар, хэмжээг хянадаг ба малчдын худаг, булаг шандаас дээж авч, хөрсний усны статик түвшинг хянадаг.

Манай компани малчдын худгийн усны

чанарын хяналт, Өмнөт болон Зөвч-Овоо талбайн ГДУО үйлдвэрлэлийн туршилтын талбайд байгуулсан хяналтын цооногт хийх усны хяналт, бүс нутгийн гидрогеологийн хяналт шинжилгээ гэсэн үндсэн 3 төрлийн хяналтыг хийдэг. Уг хөтөлбөрийг байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган, БОАЖА-аар батлуулан хэрэгжүүлдэг.

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

Чанарын хяналт: магадлан итгэмжлэгдсэн үндэсний лабораториудад шинжилгээгээ хийлгэхийн зэрэгцээ Францын CIME (Innovation Center for Extractive Metallurgy буюу Металлургийн олборлох үйлдвэрлэлийн инновацийн төв) лабораторид усны дээжээ илгээж зарим шинжилгээг хийлгэдэг.



УСНЫ ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨРӨЛ

Малчдын худгийн усны чанар:

“Бадрах Энержи” компани жил бүр өөрийн талбайд байрлах 8 худаг болон 1 булгийн усны чанарт хяналт шинжилгээ хийж, үр дүнг холбогдох байгууллагад тайлагнадаг. Эдгээр худаг нь гадаргуугийн өнгөн хөрснөөс байгалиасаа тэжээгддэг. Компани нутгийн иргэдийн хамт тусгай зөвшөөрөлтэй талбайн гадна байрлах малчны зарим худгуудад зохих хяналтыг хийх, уст цэгийн тооллого хийж чанарын судалгаа хийх зэрэг ажлыг зохион байгуулдаг.

Говийн бүсийн усны чанар нь Монгол орны хойд бүсийн усны чанартай адилгүй. Говийн бүсийн усан дахь зарим химийн элементийн дундаж агуулга байгалиасаа зөвшөөрөгдөх хэмжээнээс өндөр байдаг. Тухайлбал, хүнцэл, мөнгө, хар тугалга, манганез, зэс, төмөр, фтор, бериллий гэх мэт элементийн агуулга Говийн бүсийн усанд зөвшөөрөгдөх хэмжээнээс байгалиасаа өндөр байдаг.

Уг ажлын үр дүнг БОАЖА, Галба өөш долоодын говийн сав газрын захиргаа хянадаг.

“Бадрах Энержи” компани малчны хуучин худгийг сэргээн засах төслийг хэрэгжүүлж ирсэн ба нийт 60 гаруй худгийг сэргээн засварлаад байна.

Газрын доорх усны чанарын хяналт шинжилгээ:

Газрын доорх уст давхаргад ГДУО технологийн үзүүлж болзошгүй нөлөөг хянах нь өндөр ач холбогдолтой.

Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтын хувьд газрын доорх уст үеүдийг олборлолтын торлолын дотор, гадна талд байгуулсан нийт 35 хяналтын цооногийн сүлжээгээр дамжуулан хянаж байна.

Малчдын худаг байрлах гадаргын усыг хяналтын цооноогоор хянахын зэрэгцээ Зөвч-Овоо орд байрлах бүсийн хэмжээний гидрогеологийн нөхцөлийг нийт 200 гаруй цооногийн тусламжтай хянаж байна.

ОНЦЛОХ НЬ

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтыг байгаль орчны, тэр дундаа гадаргын болон газрын доорх усны гэнэтийн бохирдолгүй амжилттай гүйцэтгэж дуусгалаа. Компани усны чанарт байнгын хяналт тавихаас гадна усны экосистем, хэмжээ, чанарт үйл ажиллагаанаас нөлөөлөл үзүүлээгүй гэдгийг баталж, дотоодын болон гуравдагч талын мэргэжлийн судалгааг тогтмол хийлгэдэг. Үйлдвэрийн шингэн хуримтлуулах сан дахь уснаас тогтмол дээж авч, хянаж ажилладаг. Дээрх хяналтын тайланг эрх бүхий байгууллагад тогтмол илгээж, хянуулдаг.

2021 оны 12 дугаар сард Дорноговь аймгийн Засаг даргын хүсэлтийн дагуу хөндлөнгийн мэргэжлийн байгууллага усны аудит хийж, Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтад ашигласан ГДУО технологиос нөлөөлөл үзүүлээгүйг тогтоосон.



ОНЦЛОХ НЬ

Компанийн үйл ажиллагаанаас байгаль орчин, тухайлбал усанд нөлөө үзүүлээгүйг хянах, баталгаажуулах зорилгоор байгаль орчны хараат бус хяналт, шинжилгээг зохион байгуулж ирлээ. 2016 оноос дараахь хараат бус байгаль орчны хяналт хийгдсэн.

- 2016 он: Цаг уур, байгаль орчны хяналтын агентлаг,
- 2020 он: Байгаль орчны хяналтын мэргэжлийн байгууллага болох “Хатандалай” ХХК,
- 2021 он: Монгол Улсын Шинжлэх ухааны академи.

Ус ашиглалт

Компанийн тусгай зөвшөөрлийн талбайд байрлах бүх худагт усны тоолуур суурилуулсан бөгөөд тэдгээрийг Улаанбадрах сумын мэргэжилтнүүд хянадаг.

Тухайн жилд ашиглах усны хэмжээнээс хамаарч ус ашиглах зөвшөөрлийг Галба өөш долоодын говийн сав газрын захиргаа эсвэл Байгаль орчны газраас авдаг.

Дүгнэлт гарснаар “Бадрах Энержи” компани ус ашиглах гэрээг сумын захиргаатай байгуулж, ус ашигласны төлбөрийг сумын татварын хэлтэст цаг хугацаанд нь төвлөрүүлж ажиллаж байна.

Ажилтнууддаа мэдлэг, мэдээлэл өгөх ялангуяа усны хэрэгцээгээ оновчлох тал дээр мэдлэгжүүлж, зөв хэвшлийг дадал болгоход “Бадрах Энержи” компани анхааран ажилладаг.

Компанийн усны зарцуулалтын мэдээлэл:

2020 / ковид 19-ийн нөлөөллөөс үйл ажиллагаа доголдсон	3359 м³
2021*	6204 м³
2022	6275 м³

* ажилчдын тоо нэмэгдэж, үйлдвэрлэлийн туршилт хийгдсэн

Усны хэрэглээндээ үндэслэж төлсөн жилийн ус ашиглалтын төлбөр:

2020	4'563'673.00 төгрөг
2021	8'429'003.00 төгрөг
2022	8'525'466.00 төгрөг

Орано группийн ГДУО аргаар ашиглаж буй орд нь гүнийн уст давхаргад байршилтай байдаг. Гүнийн уст давхаргын усны чанар нь ерөнхийдөө их давсархаг, байгалиасаа уран болон бусад металлын агууламж өндөртэй байдаг тул орон нутгийн иргэд ундандаа ашиглах боломжгүй.

ГДУО аргаар олборлолт явуулахдаа олборлолтын блокийг ашиглалтад шилжүүлэхээс өмнөх бэлтгэл ажлын үед хүдрийн биетийн нүх сүвэнд орших усыг соруулж, хүчилжүүлнэ. Үүний дараа уг хүчилжүүлсэн усыг тухайн хүдрийн биет рүү блокийн хэмжээнд нь буцаан шахна. Ийнхүү хүчилжүүлэх үйл явцыг pH буюу саармаг орчныг зөвхөн ураныг сонгож уусгах боломжтой болох түвшин хүртэл нь давтана. Энэхүү эргэлтийн хүчилжүүлсэн ус нь ГДУО олборлолтын үйл явцын гол бүрэлдэхүүн хэсэг бөгөөд “ашигласан ус”-д тооцогдохгүй ба битүү эргэлтээр эргэлдүүлж дахин ашигладаг. 2022 онд Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтын хүрээнд 17,272 м3 усыг хүчилжүүлэх явцад ашигласан.

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

Олон нийтийн оролцоотой байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг 2013 оноос малчдын оролцоотой хэрэгжүүлж эхэлсэн. Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтын төсөлд зориулж малчид тус хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцож, усны дээжийг биечлэн авч, хамтарсан хяналтыг хэрэгжүүлэв. Уг хөтөлбөрийн үр дүнгээр ГДУО үйлдвэрлэлийн туршилтаас байгаль орчинд нөлөө үзүүлээгүйг баталгаажуулсан.



Хог хаягдлын менежмент

Уул уурхайн төслийн үе шат бүрт хог хаягдлын менежментэд онцгой анхаарах нь чухал байдаг.

“Бадрах Энержи” ХХК компани бага цацраг идэвхт мөн ахуйн хог хаягдлаа бүрэн хариуцан, хог хаягдлын менежментийг хууль тогтоомжийн дагуу мөн оновчтой зохион байгуулдаг. Хог хаягдлын хэмжээ, боловсруулалт үйл ажиллагаанаас хамаарч жил бүр харилцан адилгүй байдаг ч хаягдлын хэмжээг багасгах, нөлөөг бууруулах зорилго тавьж ажилладаг. Компани хог хаягдлаа эх үүсвэр дээр нь ангилан ялгаж, дахин боловсруулах компанид шилжүүлдэг ба шилжүүлэхээс өмнө аюулгүй хадгалж, холбогдох тайлангаа эрх бүхий байгууллагуудад хүргүүлж, мэдээлдэг. Энэхүү ажлыг мөн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд гүйцэтгэж, үнэлүүлдэг болно.

Ахуйн хог хаягдал

Хоол хүнсний буюу гал тогооны хаягдал, ажилчдын болон оффисын байрны хог хаягдал зэрэг дахин боловсруулахгүй хаягдлыг ахуйн хог хаягдалд оруулдаг.

Ахуйн хог хаягдлыг килограммаар илэрхийлэхэд:

- 2020 онд 2,075 (үйл ажиллагаанд Ковид 19 цар тахал нөлөөлсөн)
- 2021 онд 2941.2 (үйл ажиллагаанд Ковид 19 цар тахал нөлөөлсөн)
- 2022 онд 5851.5

2022 онд компанийн хээрийн анги бүрэн хүчин чадлаараа ажилласан ба ажилчид болон гэрээлэгч компанийн ажилтны тоо нэмэгдсэн.

Үйлдвэрлэлийн хог хаягдал

Үйлдвэрт ашигласан хуванцар, сав баглаа боодлын материал, мод, дугуй, төмрийн хаягдал, барилгын бусад хаягдлууд үйлдвэрлэлийн хог хаягдалд орно.

“Бадрах Энержи” компанийн 2021–2022 онд гүйцэтгэсэн Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтаас бага хэмжээний үйлдвэрлэлийн хог хаягдал гарсан. Манай компани цашид гүйцэтгэхээр төлөвлөсөн төслийн барилга угсралт, хөгжүүлэлтийн шатанд үйлдвэрлэлийн хог хаягдлыг аль болох бага түвшинд байлгах зорилго тавьж байна.

Бага цацраг идэвхт болон химийн бодисоор бохирдсон хог хаягдал

Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтын боловсруулалтын шат болон лабораториос (шингэн хуримтлуулах сангаас гадна) тодорхой хэмжээний бага цацраг идэвхт болон химийн бодисоор бохирдсон хог хаягдал гарсан.

Тухайлбал, Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтын хугацаанд 900 кг хатуу идэвхт хаягдал мөн 560 л шингэн бага цацраг идэвхт хаягдал тус тус үүссэн.

Бүх хог хаягдлаа газар дээр нь ангилан ялгаж, зориулалтын байгууламжид хадгалж байна. Үүнд:

- Бага цацраг идэвхт хог хаягдлыг зориулалтын буюу цацрагийн хяналтын бүсэд хадгалж, цацрагийн хяналтыг байнга гүйцэтгэж байна. Үйлдвэрлэлийн туршилтын үйл ажиллагааны үед энэ төрлийн хог хаягдлын хэмжээг бууруулахад анхаарч, овор хэмжээг бууруулж ажилласан.

- Лабораториос гарсан химийн бодисын хог хаягдлыг дахин боловсруулах, устгах тусгай зөвшөөрөл бүхий компанид стандартын дагуу шилжүүлж ажиллав.

Жилд гарах нийт хаягдлын хэмжээ нь хээрийн анги дээрх үйл ажиллагааны төрөл, засвар үйлчилгээний ажлын хэмжээнээс шууд хамааралтай.

“Бадрах Энержи” компани бүх хуванцар хаягдал, ашигласан тосыг дахин боловсруулахаар зорьж байна. Компани нь хог хаягдлаа ангилан ялгах, дахин боловсруулах ажилд бүх ажилтнуудаа оролцуулахад өндөр ач холбогдол өгч, нийт ажилтнуудаа хог хаягдлынхаа хэмжээг бууруулахад уриалж, хамтран ажилладаг. Хог хаягдлын хэмжээ жил бүр ялгаатай байдаг хэдий ч энэ ажилд бүх багийн оролцоо, хүчин чармайлт чухал байдаг.

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

“Бадрах Энержи” компани нь хог хаягдлын менежмент хийхдээ дараах зарчмыг баримталдаг:

- Урьдчилан сэргийлэх,
- Дахин ашиглах,
- Дахин боловсруулах,
- Устгалд оруулах.

Эдгээр хүчин чармайлт нь бохирдлоос урьдчилан сэргийлэх, хог, хаягдлын менежментийг сайжруулах, хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх аливаа нөлөөг арилгах зорилготой юм.



Уур амьсгал: 2050 он хүртэл нүүрстөрөгчийг саармагжуулах зорилгод хувь нэмэр оруулах нь

Орано групп жил бүр хүлэмжийн хийн ялгаруулалтдаа хөндлөнгийн аудит хийлгүүлж, үр дүнг нь нийтэлж мэдээлдэг. “Бадрах Энержи” компани хүлэмжийн хий бууруулах зорилгод хувь нэмрээ оруулж, холбогдох мэдээллээ дотоод системээр илгээж, тайлагнадаг.

Эрчим хүч (Тэннаксия-аас авав)

Мегаватт цаг	2020	2021	2022
Хэрэглэсэн шатамхай эрчим хүч	2 337,77	1 896,48	2 462,45
Хэрэглэсэн цахилгаан	825	566	615
Хэрэглэсэн эрчим хүч	3 162,77	2 462,48	3 077,45

Хээрийн анги дээрх үйл ажиллагаа Ковид 19 цар тахлын нөлөөнд өртсөн ба үйл ажиллагаа эргээд сэргэхэд эрчим хүчний хэрэглээ өсөхийн хирээр нүүрстөрөгчийн ялгарал ч мөн өссөн.

Тэннаксия-ийн дагуух 1 болон 2-р доод үзүүлэлт

CO2-ийн ялгарал тонноор	2020	2021	2022
Нүүрстөрөгчийг шуудаар ялгаруулах 1-р үзүүлэлт	635,7	515,7	697,15
Нүүрстөрөгчийг шууд бусаар ялгаруулах 2-р үзүүлэлт	1230,9	844,47	916,09

Эрчим хүчний аюулгүй байдлын төлөө

Компанийн үйл ажиллагааг тасралтгүй мөн найдвартай явуулахад “Бадрах Энержи” ХХК эрчим хүчний хангамжаа баталгаажуулж, нүүрстөрөгчийн ялгаруулалтаа бууруулж, эрчим хүчний хэрэглээгээ оновчтой болгох хүчин чармайлтаа үргэлжлүүлэх шаардлагатай. Манай компани нь шатамхай түлш, сэргээгдэх эрчим хүч хэрэглэхээс үл хамааран эрчим хүчний хэрэглээгээ тогтмол хянадаг.

Өрмийн шаврын менежмент – Шаврын сан

ГДУО технологи нь хүдрийн хаягдал үүсгэхгүй мөн хаягдлын байгууламж шаардлагагүй зэрэг давуу талуудтай.

Цооног өрөмдөх явцад үүсдэг шаврын хаягдлыг шаврын санд стандартын дагуу хадгалж, нөхөн сэргээдэг.

Шаврын санд цацрагийн болон химийн хяналт, шинжилгээг хийж, хяналтын цооногээр нэвчилтийг хянадаг. Дулаан-Уул шаврын

сангийн хяналтыг 2009 оноос, Зөвч-Овоо шаврын сангийн хяналтыг 2010 оноос тус тус өдийг хүртэл тасралтгүй хийж байна.

Талбайн нөхөн сэргээлт

Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтын талбайд үндсэн үйлдвэрлэлийн үе шатанд дахин олборлолт хийх ба уг талбайг бүрэн ашиглаж дууссаны дараа нөхөн сэргээхээр төлөвлөсөн.

“Бадрах Энержи” компанийн Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтын талбай нь тогтмол хяналтад байх ба ГДУО-ын технологийн үе шат бүрийг харуулах зорилгоор олон нийтэд ил тодоор үргэлжлүүлэн үзүүлж, танилцуулна.

Татан буулгах төлөвлөгөөний гол зорилтууд нь дараах юм. Үүнд:

- Нийгмийн эрүүл мэнд, аюулгүй байдлын хувьд урт хугацаанд тогтвортой байдлыг хангах;



- Үлдэгдэл нөлөөллийн хэмжээг аль болох боломжит хамгийн бага хэмжээнд бууруулах (ALARA);
- Биологийн олон янз байдлыг хадгалах, талбайн уламжлалт ашиглалтын зориулалтыг нэмэгдүүлэх зорилгоор үйл ажиллагааны талбайг ойр орчмын байгаль орчны нэг хэсэг болгоход анхаарах;
- Уст үеийн нөхцөлийг үйлдвэрлэлийн туршилтаас өмнөх байдалд нь дөхүүлэх;
- Орон нутгийн оролцогч талуудыг татан буулгах төлөвлөгөөнд оролцуулах;
- Талбайг холбогдох захиргааны байгууллагад шилжүүлэх ажлыг хөнгөвчлөх зорилготой юм.

Байгаль орчинд хамаарах осол, зөрчлийг тайлагнах

Байгаль орчны бүх осол, зөрчлийн тохиолдлыг Орано группийн хэмжээнд “AHEAD” дотоод системээр дамжуулж мэдээлж, бүртгэдэг ба байгаль орчны осол зөрчил, осолд дөхсөн тохиолдлын аюулын зэргийн ангилал болох “ASSESS”-ийг ашиглан үнэлдэг. Ийнхүү үйл ажиллагааны төгөлдөршил, группийн хэмжээнд мэдээлэл хуваалцах явдлыг хөхүүлэн дэмжиж байна.

7 | БИОЛОГИЙН ТӨРӨЛ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ



УУЛ УУРХАЙН ЗАРЧИМ

Биологийн олон янз байдлыг хамгаалж, газар ашиглалтын төлөвлөлтийг оновчтой болгоход хувь нэмэр оруулах

Биологийн олон янз байдлыг хадгалж хамгаалах

“Бадрах Энержи” компани биологийн олон янз байдлыг хадгалж, хамгаалах явдлыг эн тэргүүнд тавихын сацуу үйл ажиллагаагаа хүрээлэн буй орчинд ээлтэй байдлаар нийцүүлэн явуулах нь зайлшгүй шаардлагатай гэж үздэг.

Орано группийн салбар компанийн хувьд “Бадрах Энержи” компани энэ чиглэлээр дараах үүргийг хүлээдэг. Үүнд:

- ЮНЕСКО-гийн Дэлхийн өвд бүртгэгдсэн газруудад шинээр эрэл хайгуул хийж, ашиглалт явуулахаас зайлсхийх,
- Хуулиар «хамгаалалттай газар» гэж тогтоосон газар нутгийг хүндэтгэх, тухайн газруудад шинээр үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлэх болон одоо явагдаж байгаа үйл ажиллагааг өөрчлөхдөө тухайн газар нутгийг тусгай хамгаалалтад авсан үнэт чанарт нь нийцүүлэх, сөрөг нөлөө үзүүлэхгүй байх,
- Нөлөөлөл шатлан бууруулах зарчмаар биологийн олон янз байдал, экосистемийн үйлчилгээнд үзүүлэх эрсдэл, нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, бууруулах үүрэг хүлээж байна.

Энэ нь Орано Майнинг компанийн зарчим болон Олон улсын санхүүгийн корпорацийн “Биологийн олон янз байдлын хамгаалал, амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент”-ийн тухай 6-р гүйцэтгэлийн стандартад бүрэн нийцдэг. Орано групп биологийн олон янз байдлыг хамгаалах, экосистемийн үйлчилгээг хадгалах, амьд байгалийн нөөцийн тогтвортой менежмент хэрэгжүүлэхийг уг зарчмын гол цөм болгож, бүх үйл ажиллагаандаа тогтвортой хөгжлийг хангах тэргүүлэх чиглэлүүдэд зүй ёсоор оруулдаг.



I Бидний биологийн олон янз байдлын талаарх өгсөн амлалт

Амьдрах орчин нь төслийн талбай дотор байрлах ховордсон амьтдын нийт тоо толгойг гаргахад төслийн БОННУ судалгаа чухал ач холбогдолтой. Тус тооллого, үнэлгээний зорилго нь компанийн үйл ажиллагаанаас ургамал, амьтны тодорхой төрөл зүйлд үзүүлж болзошгүй нөлөөллийг үнэлж, доройтуулахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах явдал юм.

I Биологийн төрөл зүйлд нөлөөлөх эрсдэлийг бууруулах нь

Манай компанийн ажилтнууд аливаа нөлөөллөөс “зайлсхийх-бууруулах-нөхөн сэргээх-дүйцүүлэн хамгаалах”-ын төлөө хамтран ажиллаж, экосистемийг хадгалан хамгаалдаг. Бид Олон улсын уул уурхайн металлын зөвлөлийн гишүүн компаниудын шилдэг туршлагаас суралцаж, хээрийн ангиуддаа тодорхой үйл ажиллагааг холбогдох шаардлагад нийцүүлэн хэрэгжүүлдэг.

Дорноговь аймаг дахь компанийн төслийн талбай нь говийн бүсийн өвөрмөц төрөл зүйл болох заган ойн зурвастай хэсэг газраа давхцсан байдгаараа онцлог юм. Манай компани МУИС-ийн Ойн генетик, экофизиологийн лаборатори, “ЭЖИС Монгол”

ХХК болон Францын Олон улсын хөгжлийн төлөө газар тариалангийн судалгааны төвтэй хамтран экосистемийн дүйцүүлэн хамгааллын судалгааны ажлуудыг эхлүүлэн амжилттай хэрэгжүүлээд байна.

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

Компанийн тусгай зөвшөөрөлтэй талбайд анхлан хэсэгчлэн орсон байсан Баянширээ нь Цэрдийн галавын үлэг гүрвэлийн олдворуудаараа алдартай газар юм. Тус талбайд археолог, палеонтологийн судалгааг хийж улмаар Баянширээ уулын хэсгийг хамгаалах зорилгоор хэсэгчлэн буцаасан ба 2014 оны 12 дугаар сард энэ газрыг ЮНЕСКО-ийн жагсаалтад оруулахаар Монгол Улсын Засгийн газраас санал болгосон.

Орон нутгийн хамгаалалтад байдаг 2512 га талбайг хамарсан Хар загийн ой нь Зөөвч-Овоо тусгай зөвшөөрөлтэй талбайн захад оршдог. Бүрдэнийн рашааны байгалийн нөөц газар мөн тусгай зөвшөөрөлтэй талбайн зүүн талд, Аравнайн богд уулын баруун талд (ОУЦХН-ийн 4-р зэрэглэл) Дулаан-Уул, Зөөвч-Овоо орд орчмоос 100 орчим км-ийн радиуст оршдог.

Компанийн тусгай зөвшөөрөлтэй талбайн хэмжээн дэх амьтдын тооллогыг байгаль орчны суурь үнэлгээгээр хийсэн. Жишээлбэл, амьтны аймагт (IUCN ангиллаар): 11 төрөл



зүйлийн ховор, 1 төрөл зүйлийн нэн ховор амьтад бүртгэгдсэн. Монгол Улсын Улаан номд заасан ангиллын дагуу бусад амьтдын төрөл зүйлийг мөн бүртгэлжүүлэв. Үүнд subguttura gazelle (хар сүүлт зээр, эмзэг төрөл), equus hemionus (хулан, устах аюулд орсон), мөн 7 төрлийн ховор, 4 төрлийн нэн ховор амьтад буйг тодорхойлов. Мөн IUCN ангиллаар Subguttura gazelle нь эмзэг, equus hemionus нь нэн ховор төрөл зүйлд багтдаг.

I Дүйцүүлэн хамгаалах төсөл

Уул уурхайн үйл ажиллагаанаас биологийн олон янз байдалд үзүүлэх нөлөөллийг бууруулахын тулд “нөлөөллийг бууруулах шат дараалсан арга хэмжээг” төслийн анхны үе шатаас эхлүүлэн хэрэгжүүлж ирсэн. Бид биологийн төрөл зүйлд хамгийн бага нөлөөлөх буюу аливаа төрөл зүйлийг устгахгүй байх зорилготой. Зөвч-Овоо ГДУО үйлдвэрлэлийн туршилтын бүсийн бэлтгэл ажлын хүрээнд хийгдсэн БОННУ –ээр тодорхой тооны заг мод зайлшгүй устана гэж тодорхойлсон байдаг.

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

2021 оны 11 дүгээр сард “Бадрах Энержи” ХХК томоохон уул уурхайн компаниудын хамт Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Нэг тэрбум мод” үндэсний хөтөлбөрт нэгдэн орж, уурхайн ашиглалтын хугацаанд 5 сая мод тарих амлалт авлаа.

Иймд “Бадрах Энержи” компани экологийн дүйцүүлэн хамгаалах төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргаж ажилласан.

Төсөл эхлэхийн өмнөх үе шатанд ихэнх барилга, байгууламжийг заг модны нягтшил ихтэй бүсээс гадна барьж, байгуулах ба “Бадрах Энержи” компани зам ашиглалтыг чангатгасан журмаар зохицуулна. Компанийн зүгээс үйлдвэрлэлийн туршилтын нөлөөлөлд өртсөнтэй адил хэмжээний талбайд (5 га) заг мод болон тухайн бүсэд зохицсон бусад төрөл зүйлийг тарих, суулгах санал оруулсан.

Дүйцүүлэн хамгаалах ажлыг туршилтын бүсийн ойролцоо, мод тогтвортой ургах боломжтой талбайд, оролцогч талуудын зөвшилцсөн цэгт, нутгийн уламжлалын дагуу эхлүүлсэн.



Нийгмийн болоод байгаль орчны эерэг хандлагыг бүрдүүлэхийн тулд оролцогч талууд дүйцүүлэн хамгаалах уг арга хэмжээнд оролцоходоо биологийн олон янз байдлыг дүйцүүлэх хөтөлбөр, хуурай бүс нутагт мод суулгах чиглэлээр мэргэшсэн орон нутгийн компаниуд, мэргэжилтнүүдээр уг ажлыг гүйцэтгүүлэхийг дэмжив.

Таван жил явагдсан судалгааны дараа, 2021 онд моджуулах ажлыг компанийн талбайд эхлүүлсэн бөгөөд 2024 он хүртэл хэрэгжинэ. Мод, суулгацын өсөлтийн хяналтыг цаашид 4 – 5 жил үргэлжлүүлэн хийнэ.

Дүйцүүлэн хамгаалах төслийг тоогоор илэрхийлбэл:

- 3 жилийн хугацаанд нийт 12,500 мод тарив (2020–2022)
- Модны ургалтын хувь: 75–85 хувь (стандарт ургалтын хувь дунджаар 45–60 байдаг)
- 11,000 ширхэг суулгац тарьж бэлтгэв
- Сум, орон нутгийн иргэд идэвхтэй оролцлоо
- Улирлын чанартай 15 ажлын байр бий болгов
- “Нэг зочин–Нэг мод” төслийн хүрээнд 2022 онд 380 хүн манай талбайд мод тарьж бидний төсөлд оролцсон.

ОНЦЛОХ НЬ

8 | ХАРИУЦЛАГАТАЙ ҮЙЛДВЭРЛЭЛ



УУЛ УУРХАЙН ЗАРЧИМ

Метал болон эрдэс агуулсан бүтээгдэхүүний ашиглалт, дахин ашиглалт болон дахин боловсруулалт, түүний хаягдал болон хариуцлагатай уул уурхайн талаарх систем, үндсэн мэдлэгийг дэмжих, хэрэгжүүлэх

2021-2022 оны Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилт

"Бадрах Энержи" ХХК Зөвч-Овоо ордоос уран олборлож, боловсруулах үйлдвэрлэлийн туршилтыг 2021 оны 7 дугаар сараас 2022 оны 12 дугаар сар хүртэлх хугацаанд амжилттай гүйцэтгээд байна.

Тус үйлдвэрлэлийн туршилтыг тухайн ордоос уран олборлоход хамгийн тохиромжтой аргыг тодорхойлох зорилгоор хийсэн. Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтаар дараах зорилтуудыг тавьж ажиллав. Үүнд:

- ТЭЗҮ-д нэмэлт тодотгол оруулахад шаардлагатай өгөгдөл, мэдээлэл цуглуулж, техник, эдийн засгийн үзүүлэлтийг баталгаажуулах,
- ГДУО технологи нь таамаглаж байсанчлан байгаль орчинд бага нөлөөтэйг баталгаажуулах,
- Сум орон нутгийн иргэдийг үйлдвэрлэлийн туршилтын хяналтын үйл ажиллагаанд татан оролцуулснаар төслийг нийгэмд ээргээр хүлээн зөвшөөрүүлэх явдлыг дэмжих байв.

Зөвч-Овоо үйлдвэрлэлийн туршилтыг хөдөлмөрийн аюулгүй байдал мөн байгаль орчны осол аваар гаргалгүй хийж гүйцэтгэлээ.

Уран олборлож, боловсруулах техникийн бүх үйл явцыг (өөрөөр хэлбэл, металл авалт, химийн бодисын зарцуулалт, агуулга г.м) туршилтын хугацаанд туршив. Үйлдвэрлэлийн туршилтын үр дүнд "Бадрах Энержи" компани нь 10 гаруй тонн байгалийн ураныг амжилттай үйлдвэрлээд байна.

Ийнхүү, ихэнх нь орон нутгийн иргэдээс бүрдсэн үйлдвэрлэлийн туршилтын баг ГДУО технологийг аюулгүй ашиглаж, ажиллаж чадахаа амжилттай батлан харууллаа. Үйлдвэрлэлийн туршилтад бүхэлдээ Монгол ажилтнууд ажилласан (үйлдвэрлэлийн талбайд ажилласан 52 ажилтнаас 2 нь гадаад мэргэжилтэн байсан бөгөөд нийт ажилтны 50 хувийг орон нутгийн залуучууд бүрдүүлж байв).

Үйлдвэрлэлийн туршилт өндөрлөж төслийн хөрөнгө оруулалт хийгдэж эхлэх хугацаанд үйлдвэрлэлийн туршилт дээр ажилласан ажилтнуудад анхаарал хандуулан, сургалтад хамруулж, мэдлэг, үр чадвараа сайжруулан бэхжүүлэх боломжийг бүрдүүлэн ажиллана.



ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

Төслийн явцын талаарх мэдээллийг манай компани орон нутгийн иргэд, малчдад тасралтгүй өгөв. Төрөл бүрийн ажил мэргэжлийн 700 гаруй хүн (багш, оюутан сурагч, сэтгүүлч, малчин г.м.) үйлдвэрлэлийн туршилтын талбайд зочилж, туршилтын явцтай танилцлаа.

Үйлдвэрлэлийн туршилтын дараа ч төслийг сонирхсон иргэдэд үйлдвэрлэлийн туршилтын үйлдвэр, барилга байгууламж дээр очиж, танилцах боломж нээлттэй хэвээр байхаас гадна боловсруулах үйлдвэрийн байгууламжийг ирээдүйд уурхайн оператороор ажиллах ажилтнуудын сургалтын төвөөр ашиглах бүрэн боломжтой.



I Төслийн дараагийн шат

Зөвч-Овоо ордын ТЭЗҮ-ийн нэмэлт тодотголыг 2023 оны хоёрдугаар улиралд багтаан хүргүүлэхийн зэрэгцээ Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг мөн хүргүүлэх төлөвлөгөөтэй байна.

Орано групп нь 30 гаруй жил үргэлжлэх Зөвч-Овоо төслийн ирээдүйг баталгаажуулах харилцан ашигтай Хөрөнгө оруулалтын гэрээг Монгол улсын Засгийн газартай байгуулах зорилт тавин ажиллаж байна.

Уг Хөрөнгө оруулалтын гэрээ нь Монгол улсын хууль журамд нийцсэн байхын зэрэгцээ Монгол улсын засгийн газраас соёрхон баталсны дараа ил тод зарчмын дагуу олон нийт гэрээтэй танилцах боломжтой болох юм.

9 | НИЙГЭМД ЧИГЛЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА



УУЛ УУРХАЙН ЗАРЧИМ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, гүйцэтгэлээ тасралтгүй сайжруулахыг эрэлхийлж, үйл ажиллагаа явуулж байгаа улс орон болон иргэдийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах.

Орано Майнинг компани нь хариуцлагатай уул уурхайн компанийн хувьд мөн 2011 онд Олон улсын уул уурхай, металлын зөвлөлийн гишүүн болсноор тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулж, уул уурхайн төслүүдээ хэрэгжүүлэхдээ орон нутгийн соёл, уламжлал, онцлог шинж чанартай нийцүүлэх амлалт үүрэг авсан билээ.

I Сум, орон нутгийн хүлээлтэд нийцэх нь

“Бадрах Энержи” ХХК нь орон нутгийн оролцогч талуудын хүлээлтийг харгалзан үзэж байгаагаар баталгаажуулах үүднээс тогтмол уулзалт хурал зохион байгуулдаг. Компани нь орон нутгийн оролцогч талуудтай яриа хэлэлцээ өрнүүлсний үр дүнд байгаль орчин, хөдөлмөрийн харилцаа, нийгэм, эдийн засаг болон засаглалтай холбоотой асуултуудад стратегийн түвшний тэргүүлэх чиглэлүүдээ гарган, үйл ажиллагааны төлөвлөгөөгөө тодорхойлж чадсан.

“Бадрах Энержи” компани нь үйл ажиллагаа явуулдаг Дорноговь аймгийн Улаанбадрах сум болон Сайншанд сумын Зүүнбаян багийн нийгэм эдийн засгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөр хэрэгжүүлдэг.

Компани нь орон нутгийн харилцаа хариуцсан багтай бөгөөд нийгмийн хөрөнгө оруулалтын үр нөлөө болон тэдгээрийн байнгын мэдээлэл харилцааг баталгаажуулан ажилладаг. Энэ баг нь орон нутгийн хэрэгцээ, шаардлагыг судлан үнэлж, компанийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллээр хангадаг.

I Зөвч-Овоо төслийн оролцогч талууд болон тэдэн рүү чиглэсэн үйл ажиллагааг дэмжих нь

“Бадрах Энержи” компани сум, орон нутгийн иргэдийн хэрэгцээнд нийцсэн эрүүл мэнд, байгаль орчин, усны хүртээмж болон боловсролын төслийг орон нутгийн оролцогч талуудтай зөвлөлдөн ярилцаж, хамтран хэрэгжүүлсээр ирсэн. Эдгээр төсөл нь орон нутгийн иргэдийн сайн сайхан болон эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулдаг.

I Хамтын ажиллагааны гэрээ

“Бадрах Энержи” ХХК нь үйлдвэрлэлийн туршилтын шатанд 2018 онд Дорноговь аймгийн Улаанбадрах сум, Сайншанд сумын




Зүүнбаян багтай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, орон нутгийн удирдлага, иргэдтэй яриа хэлэлцүүлэг хийх албан ёсны тогтолцоо бий болгосон. Хамтын ажиллагааны гэрээг дараах 7 үндсэн чиглэлээр байгуулсан:

- Эдийн засгийн хөгжил,
- Боловсрол,
- Эрүүл мэнд,
- Мал аж ахуй,
- Соёл,
- Усны хүртээмж,
- Эрчим хүчний хүртээмж.

Хамтын ажиллагааны гэрээ ёсоор хэрэгжүүлэлтийн хороо, харилцаа холбооны хороо ажилладаг. Эдгээр хороо нь 2021 онд

хоёр удаа, 2022 онд гурван удаа уулзалт хийсэн ба дээрх хорооны оролцогч талуудын төлөөлөл төсөл, хөтөлбөрийн санал хүлээн авах, боловсруулах, сонгох, хяналт тавих, шалгах ажлуудыг гүйцэтгэх үүрэгтэй.

ОНЦЛОХ НЬ
Компани уурхайн бэлтгэл ажлын шатанд буюу олборлолтын шат эхлэх хүртэл жилд 1 тэрбум төгрөгийг сум, орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийг дэмжсэн төсөл, хөтөлбөрт зарцуулахаар төлөвлөөд байна.



ТӨСЛҮҮДИЙН ЖИШЭЭ

Эдийн засгийн хөгжил

МАЛЖУУЛАХ ТӨСӨЛ

Залуус төв суурин газар амьдрах хүсэлтэй болж, малчин өрхийн тоо жилээс жилд цөөрч байна. Малжуулах төсөл нь ирээдүйд малчин болох хүсэлтэй залуус мөн цөөн тооны малтай малчин өрхүүдийг дэмжих зорилготой төсөл юм.

2013 оноос хойш уг төсөлд Зүүнбаян багаас 38 малчин өрх, Улаанбадрах сумаас 86 малчин өрх, нийт 124 өрх айл хамрагдсан.



ОРОН НУТГИЙН ХАНГАН НИЙЛҮҮЛЭГЧДИЙГ ДЭМЖИХ НЬ

“Бадрах Энержи” компани нь ханган нийлүүлэгчидтэйгээ урт хугацаанд ил тод харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхийг эрмэлзэж, үйл ажиллагааных нь стандартыг (аюулгүй байдал, чанар, тогтвортой байдал, ил тод байдал гэх мэт) нэмэгдүүлэхэд нь дэмжлэг үзүүлэхийн тулд группийн мэргэжилтнүүдтэй хамтран сургалт зохион байгуулж, сайн туршлууудаа хуваалцан, ханган нийлүүлэгчдийн ажилтнуудыг ажлаа гүйцэтгэхэд нь дэмжин ажилладаг.

“Бадрах Энержи” ХХК-ийн ханган нийлүүлэгчдийн 97 хувь нь Монгол Улсад бүртгэлтэй дотоодын компани байдаг нь улс орны хөгжилд хувь нэмэр оруулж буй явдал юм.

Түүнээс гадна худалдан авсан бүтээгдэхүүний 9 хувийг компанийн үйл ажиллагаа явуулдаг Дорноговь аймгаас авдаг.

Нийгмийн хөгжил

ОЮУТНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨР

“Бадрах Энержи” компани Улаанбадрах сум, Зүүнбаян багт мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэж, дэмжих зорилгоор оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг 2010 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Хөтөлбөрт нийт 72 оюутан хамрагдаад байгаа ба төгсөөд 3 жил орон нутагтаа ажиллах зохицуулалттай байдаг билээ. Хөтөлбөрт хамрагдсан оюутнуудын 60 хувь нь эмэгтэй, 40 хувь нь эрэгтэй оюутан байна. 2022 оны сүүлийн байдлаар 34 оюутан уг хөтөлбөрийн дагуу их, дээд сургуульд суралцаж байна.



ФХВ ХӨТӨЛБӨР

2016 оноос Орано Майнинг болон “Бадрах Энержи” ХХК нь Франсуэ Ксавие Бану (ФХВ) төрийн бус байгууллагатай хамтран Дорноговь аймагт төсөл хэрэгжүүлж ирсэн.

Уг хөтөлбөр нь бага орлоготой өрхүүдийг орлогын тогтвортой эх үүсвэртэй болоход нь төдийгүй нийгэм, эдийн засгийн хувьд бие даахад нь дэмжлэг үзүүлдэг.

Хөтөлбөрт хамрагдсан өрхүүдэд эрүүл ахуй, эрүүл мэнд, орон байр, боловсролын чиглэлээр төрөл бүрийн сургалт зохион байгуулахаас гадна орлогын эх үүсвэртэй болох жижиг бизнес эхлүүлэх онолын мэдлэг, практик зөвлөгөө өгч, гарааны санхүүжилтээр тусалдаг. Энэхүү гурван жилийн хөтөлбөрийн төгсгөлд төсөлд хамрагдсан өрхүүд санхүүгийн хувьд бие дааж, эргэн тойрондоо эерэг нөлөө үзүүлэх чадвартай болж байна.

2016 оноос хойш уг хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн гурван удаагийн төсөлд



Дорноговь аймгаас нийт 291 өрхийн 2000 иргэн хамрагдаж, төслийн үр шимийг хүртээд байна.

ЭРЧИМ ХҮЧНИЙ ХҮРТЭЭМЖ



2021 онд Дорноговь аймгийн Улаанбадрах сумын удирдлагаас ирсэн хүсэлт болон сум, орон нутгийн удирдлага, компанийн төлөөлөл бүхий харилцаа, холбооны хорооноос гаргасан шийдвэрийн дагуу Улаанбадрах сумыг цахилгааны шугам сүлжээтэй холбох төслийг гүйцэтгэснээр уг сумын төвийн оршин суугчдад цахилгаан эрчим хүчтэй холбогдох боломжийг бий болгосон. Цахилгааны шугам сүлжээ нь 0.4 килоВаттын хүчин чадалтай. 2006 оноос хойш компани нь Улаанбадрах сумын төвд цахилгааны шугам сүлжээг байгуулах төслийг оролцуулаад 191 сая гаруй төгрөгийг орон нутгийн оршин суугчдын цахилгааны хүртээмжийг сайжруулахад зарцуулсан.

Өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам

2020 оноос хэрэгжүүлж байгаа “Бадрах Энержи” ХХК-ийн өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэх журам нь аливаа асуудлыг шүүхийн маргаан болохоос өмнө ойлголцох, урьдчилан шийдвэрлэх зорилготой юм. Компани нь санал хүсэлтээ илэрхийлсэн гуравдагч этгээдийн тодорхой баримт бүхий өргөдөл гомдлыг хүлээн авч, шаардлагатай хариултыг цаг хугацаанд нь өгч, шийдэл олохын тулд бүх хүчин чармайлтаа дайчлан ажилладаг.

Өргөдөл, гомдол гаргагч нь тодорхой баримт бүхий өргөдөл, гомдлоо компанид гаргахад бүртгэн авсны дараа компанийн холбогдох хэлтэс, ажилтнуудын оролцоотой хоёр сарын дотор шийдвэрлэн ажилладаг. Өргөдөл гомдол, тэдгээрийг шийдвэрлэсэн талаарх тайланг жил бүр Орон нутгийн мэдээллийн зөвлөлд танилцуулдаг. 2021 болон 2022 онд өргөдөл, гомдол ирүүлээгүй байна.

10 | ОРОЛЦОГЧ ТАЛУУД



УУЛ УУРХАЙН ЗАРЧИМ

Үндсэн оролцогч талуудыг тогтвортой хөгжлийн сорилт болон боломжид нээлттэй бөгөөд ил тод байдлаар оролцуулах. Явц болон гүйцэтгэлийг үр нөлөөтэйгөөр тайлагнаж, бие даан баталгаажуулах.

“Бадрах Энержи” компанийн оролцогч талууд

Төслийн оролцогч тал гэдэг нь компанийн үйл ажиллагааны нөлөөнд тодорхой хэмжээгээр өртөж байгаа эсвэл үйл ажиллагаанд шууд болон шууд бус оролцоо, хамааралтай иргэн болон бүлгийг хэлнэ.

“Бадрах Энержи” компанийн үндсэн оролцогч талууд нь Монгол улсын төр, засгийн байгууллага, орон нутгийн иргэд, захиргааны байгууллагууд, судалгаа, шинжилгээний хүрээлэнгүүд юм.

Оролцогч талуудын хүлээлтийг таньж мэдэх нь

“Бадрах Энержи” ХХК-ийн хувьд хариуцлагатай уул уурхайн компанийн хувьд үйл ажиллагаа явуулж буй орчноо ойлгох нь зайлшгүй чухал юм.

Компанийн зүгээс төслийн оролцогч талуудтай (төр, засгийн байгууллага, орон нутгийн иргэд, ТББ, жэвлэл мэдээлэл, компанийн ажилтнууд) үр дүнтэй, бүтээлч хамтын ажиллагааг хөгжүүлэхийн тулд яриа хэлэлцээ хийх, хэлэлцүүлэг өрнүүлэх замаар үйл ажиллагаагаа танилцуулж, тэдний хүлээлт, төсөөллийг ойлгон авдаг.

- Монгол улсад болон олон улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй зохицуулалт. Эдгээр зохицуулалтын хүрээнд компани



байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг олон нийтэд танилцуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, техник, эдийн засгийн үндэслэлийн нэмэлт тодотголыг орон нутгийн захиргааны байгууллагад танилцуулсан.

- Уул уурхайн гэрээ болон гэрээний тусгайлсан заалтууд. “Бадрах Энержи” компани орд ашиглах гэрээг Ашигт малтмал, газрын тосны газартай 2016 онд байгуулсан. Уг гэрээний дагуу Зөвөч-Овоо орд дээр үйлдвэрлэлийн туршилтыг хийж гүйцэтгэсэн. 2018 онд компани болон Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян баг, Улаанбадрах сумын засаг дарга нарын байгуулсан хамтын ажиллагааны гэрээг 2022 оны сүүлчээр шинэчилсэн. Компани нь 2023 онд багтааж хамтын ажиллагааны гэрээг шинээр байгуулахаар төлөвлөж байна.
- Уул уурхайн салбарын мэргэжлийн байгууллага, холбоодоос тогтоосон хамрах цар хүрээ, стандарт. Монгол улсад ил тод харилцан яриа, бизнесийн эрүүл орчин бүрдүүлэх явдалд хувь нэмрээ оруулах зорилгоор “Бадрах Энержи” ХХК нь Уул уурхайн салбарын ил тод байдлын санаачилга, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци, АмЧам, Бизнесийн зөвлөл, Франц-Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхим зэрэг байгууллагуудад сайн дураар элссэн. Эдгээр байгууллагууд

нь Монгол улсад хөрөнгө оруулалтыг дэмжих, хууль, эрх зүйн бодлогыг сайжруулах чиглэлд дэмжлэг үзүүлдэг.

- Оролцогч талын зураглалыг тогтмол гүйцэтгэж, үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөөг боловсруулдаг. Уг зураглалыг 2012 онд Монгол улс дахь Зөвөч-Овоо төслийн хүрээнд гүйцэтгэсэн бөгөөд сүүлд уг зураглалыг 2017-2018 онд гүйцэтгэсэн.
- Оролцогч талуудтай харилцан яриа өрнүүлэх зорилготой орон нутгийн байгууллагууд. “Бадрах Энержи” компани нь 2013 онд Орон нутгийн мэдээллийн зөвлөлдүүдийг байгуулсан.

Орон нутгийн мэдээллийн зөвлөл

Сум, орон нутгийн иргэд, захиргааны байгууллагын төлөөлөл бүхий харилцан яриа өрнүүлэх зорилготой бүтэц нь нээлттэй яриа хэлэлцээ өрнүүлэх, санал бодлоо солилцох, ил тод байдлыг хангадаг. Сум, орон нутгийн иргэдтэй хамтран тогтмол зохион байгуулдаг уулзалтаар компанийн үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөлтэй холбоотой ойрын болон дунд хугацааны төлөвлөгөөний талаар мэдээлэл өгдөг.

Орон нутгийн мэдээллийн зөвлөлөөр хамгийн их яригддаг сэдэв нь байгаль орчин хамгаалал, эдийн засгийн хөгжил зэрэг юм.

ТА ҮҮНИЙГ МЭДЭХ ҮҮ?

2021–2022 онд “Бадрах Энержи” ХХК Орон нутгийн мэдээллийн зөвлөлийн уулзалтыг Улаанбадрах суманд 3 удаа, Зүүнбаян багт 2 удаа тус тус зохион байгуулав.

Орон нутгийн мэдээллийн зөвлөл

2022 оны 5 дугаар сарын 29–нд Улаанбадрах суманд зохион байгуулсан Орон нутгийн мэдээллийн зөвлөлийн уулзалтаар дараах сэдвийг хэлэлцсэн. Үүнд:

- 2022 онд гүйцэтгэсэн төсөл, тэдгээрийн үр нөлөө
- Уул уурхайн нийгмийн хороогоор баталсан төслүүд
- “Бадрах Энержи” ХХК–ийн үйл ажиллагаа, хүлээлт
- Худгийн засвар, шийдлийг сайжруулах
- Хамтын ажиллагааны гэрээ, гэрээний явцтай холбоотой орон нутгийн санал
- Уул уурхайн үйл ажиллагаа ихээр явагддаг аймгуудын орон нутгийн иргэдтэй туршлага солилцох
- Бичил бизнес ба тэдгээр дэх “Бадрах Энержи” ХХК–ийн үүрэг.

ОНЦЛОХ НЬ



Мэдээлэл, олон нийттэй харилцахад чиглэсэн үйл ажиллагаа

Компанийн хувьцаа эзэмшигчдийн санал нэгдсэн олон нийттэй харилцах үйл ажиллагааны хөтөлбөрийг 2021–2022 онд хэрэгжүүлээ. Уг хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрлэлийн туршилт, компанийн ашигласан технологи, сум, орон нутгийн иргэдээс ирсэн асуултуудад хариулт өгөхийн зэрэгцээ “Бадрах Энержи” компанийн үйл ажиллагаа, ураны салбарын талаарх худал мэдээлэлд няцаалт өгч ажиллав.



Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй нээлттэй харилцах нь

Ил тод байдлыг дэмжих зорилгоор тодорхой ажлуудыг хэрэгжүүлээд байна. 2022 онд Монголын хорь гаруй хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөлөлтэй хоёр удаагийн мэдээллийн уулзалт хийж, хэзэрийн анги дээрх үйл ажиллагаатай танилцах аялыг зохион байгуулсан. 2021 онд “Бадрах Энержи” компани нь “Мон–Атом” ХХК–иас хэвлэлийн төлөөлөлтэй зохион байгуулсан уулзалтад мөн оролцов.

Монголын Хэвлэлийн хүрээлэнгийн 25 жилийн ойгоор “Бадрах Энержи” ХХК нь баримтад тулгуурласан сэтгүүл зүйг дэмжих зорилгоор “Шилдэг эдийн засгийн сурвалжлага”, “Шилдэг эрэн сурвалжлах бүтээл”–ийн уралдааныг дэмжин ажилласан юм.

2022 оны 11 дүгээр сард компани нь Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн “Гидрогеологи, инженер геологи болон гео–экологийн талаарх хэлэлцүүлэг” эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах ажлыг дэмжин оролцов. Хуралд арван хоёр гаруй шинжлэх ухааны байгууллага мөн хувийн хэвшлийн байгууллагын 87 судлаач идэвх, санаачлагатай оролцсон юм.

УЛААНБААТАР ХОТЫН ТӨВ ТАЛБАЙД ИРГЭДТЭЙ НЭЭЛТТЭЙ УУЛЗЛАА

2022 онд Монгол Улс дахь Европын холбооны төлөөлөгчийн газраас Нийслэлийн төв Сүхбаатарын талбайд “Европын Өдөрлөг”–ийг зохион байгуулав. Монгол–Францын хамтарсан компани болохын хувьд “Бадрах Энержи” ХХК нь нийслэлчүүддээ Дорноговь аймгийн Улаанбадрах суманд явагдаж буй Зөөвч–Овоо үйлдвэрлэлийн туршилт болон түүнд ашиглагдаж буй ГДУО технологийг танилцуулан оролцсон юм. Компанийн асарт зочилсон хүмүүст “Бадрах Энержи” ХХК–ийн ажилтнууд 1997 оноос хойш Орано группийн хайгуулын компанийн хийж гүйцэтгэсэн ураны хайгуулын ажлын үр дүнд нээгдсэн орд, ордуудын нөөц нь Монгол улсын ураны бүртгэгдсэн нөөцийг хоёр дахин нэмэгдүүлсэн болон дэлхийн хэмжээний Зөөвч–Овоо ордын үйлдвэрлэлийн туршилтын үр дүнг танилцуулав.



ОНЦЛОХ НЬ

Төлбөрийн ил тод байдал

Орано групп 2003 онд Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгад нэгдэн орсон. Ингэснээр үйл ажиллагаа явуулж байгаа улс орны төр, засгийн байгууллагад төлж байгаа ашигт малтмалтай холбоотой төлбөрөө илүү ил тод болгох үүрэг хүлээсэн билээ.

Монгол Улс тус санаачилгад 2008 онд нэгдсэн бөгөөд түүнээс хойш тус улсад ажиллаж буй Орано группийн салбар компани нь Монгол улс дахь Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгад төлбөр тооцооны мэдээллээ жил бүр тайлагнаж ирлээ.

Иймээс “Бадрах Энержи” компани төр, засгийн байгууллагад төлж буй бүх төлбөрөө ил тод байдлын санаачилгын тайланд нээлттэй тусгадаг. Тайлантай <http://www.eitimongolia.mn> хуудсаар танилцаж болно.

2021–2022 оны хооронд нийт 2,10 тэрбум төгрөгийг Ашигт малтмал, газрын тосны газарт тусгай зөвшөөрлийн төлбөрт төлөөд байна.

“Бадрах Энержи” ХХК, “АРЕВА Монгол” ХХК, “Кожеговь” ХХК–ийн төлсөн татвар (2021–2022 он), тэрбум төгрөгөөр

2021	2.15
2022	6.21
Нийт 2021–2022 онд	8.36

Эх сурвалж: Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (байгаль орчны барьцаа, торгууль, хандив, орон нутгийн харилцаа, тогтвортой хөгжлийн шйлчилгээний төлбөрөөс гадна)

“Бадрах Энержи” ХХК–ийн тусгай зөвшөөрлийн төлбөрт төлсөн дүн, тэрбум төгрөгөөр

2021	1.05
2022	1.05
Нийт 2021–2022 онд	2.10

<http://www.badrakhenergy.com>
<http://www.facebook.com/badrakhenergy>



"Бадрах Энержи" ХХК

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,
Жамьян гүний гудамж-9, ИСС цамхаг, 5-р давхар
Утас: 7011 0475